

ХААН БАНК ХК-ИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Жилийн үйл ажиллагааны тайлагнал			
Тайлагнах хугацаа		2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		Нэр: ХААН Банк ХК УБГД: 000283102 РД: 2693321 Үнэт цаасны үсгэн тэмдэг: MN0KHAN05637 Хаяг: ХААН Банк Цамхаг, Чингисийн Өргөн Чөлөө-6, Стадион Оргил-1, Хан-Уул Дүүрэг 15-р хороо, Улаанбаатар 17010, Монгол Улс Утас: 1800-1917, 7515-3333/3221/, 7507-1917 И-мэйл: investor_relations@khanbank.com Вэбсайт: www.khanbank.com	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын Хөрөнгийн Бирж ХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Банк, санхүүгийн салбар	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		ПрайсуотерхаусКуперс Аудит ХХК Аудитаар бүртгүүлсэн огноо – 2010 он	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		1,912,198,000 ширхэг энгийн хувьцаа	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: Т.Буянбилэг /Хөрөнгө оруулагчдын харилцааны мэргэжилтэн, ТУЗ-ийн Ажлын алба/ Хянасан: В.Янжинлхам /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан		
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН (IFRS-д нийцсэн)			
Төгрөгөөр			2024-12-31
	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,893,765,124,731.80	5,387,120,262,705.89
1.1.1	Бэлэн мөнгө	201,506,285,091.90	169,843,089,445.23
1.1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан мөнгө (3 хүртэлх сарын хугацаатай)	1,651,159,067,622.82	960,978,152,925.38
1.1.3	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	3,039,684,494,739.99	4,256,092,323,238.35
1.1.4	Мөнгөн хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,415,277,277.09	206,697,096.93

1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	1,108,415,858,389.79	1,640,325,618,759.00
1.2.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгө	1,103,720,017,548.10	1,652,362,154,950.86
1.2.2	Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	13,300,000,000.00	6,780,000,000.00
1.2.3	Бусад хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	5,290,259,728.76	225,327,945.21
1.2.5	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн эрсдэлийн сан	-13,894,418,887.07	(19,041,864,137.07)
1.3	Хөрөнгө оруулалт	1,668,119,450,256.36	1,360,074,533,989.11
1.3.1	Арилжааны үнэт цаас	0.00	0.00
1.3.2	Борлуулахад бэлэн үнэт цаас	566,917,146,468.88	341,414,287,001.33
1.3.3	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	997,631,604,481.65	912,850,109,459.04
1.3.4	Зээл ба авлага гэж ангилсан бусад үнэт цаас	6,992,034,776.94	0.00
1.3.5	Хараат, хамтын хяналттай, охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.3.6	Барьцаанд байгаа үнэт цаас	68,104,991,830.46	85,111,769,264.22
1.3.7	Үнэт цаасанд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	41,414,529,936.67	32,645,852,634.75
1.3.8	Үнэт цаасны эрсдэлийн сан	-12,940,857,238.23	(11,947,484,370.23)
1.4	Зээл (цэвэр дүнгээр)	9,016,974,854,640.45	11,195,929,983,967.60
1.4.1	Хэвийн зээл	8,938,214,949,869.21	11,157,561,811,383.70
1.4.2	Хугацаа хэтэрсэн зээл	186,288,214,554.17	219,752,897,145.20
1.4.3	Хэвийн бус зээл	123,998,884,160.04	112,294,049,458.13
1.4.4	Эргэлзээтэй зээл	82,652,114,083.62	72,235,443,436.84
1.4.5	Муу зээл	303,334,333,077.43	332,009,641,510.35
1.4.6	Зээлийн хойшлогдсон төлбөр	-83,126,295,985.89	(103,587,293,505.28)
1.4.7	Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	118,062,549,835.40	140,791,052,504.34
1.4.8	Зээлийн эрсдэлийн сан	-652,449,894,953.52	(735,127,617,965.73)
1.5	Дериватив санхүүгийн хөрөнгө	46,521,649,848.03	29,176,723,444.80
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	6,820,398,576.79	49,345,876,302.29
1.6.1	Бусдаас авах авлага (цэвэр дүнгээр)	3,145,253,022.79	38,777,989,360.76
1.6.2	Банк, салбар хоорондын тооцоо	1,887,555,234.23	4,348,294,670.86
1.6.3	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	0.00	0.00
1.6.4	Бусад	1,787,590,319.77	6,219,592,270.67
1.7	Бусад санхүүгийн бус хөрөнгө	101,622,031,869.62	132,393,610,736.27
1.7.1	Бусад тооцоо	96,471,127,195.22	118,604,456,924.72
1.7.2	Бараа материал, үнэ бүхий зүйл	5,150,904,674.40	13,789,153,811.55
1.7.3	Үнэт металл (цэвэр дүнгээр)	0.00	0.00
1.7.4	Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр дүнгээр)	0.00	0.00
1.7.5	Татварын авлага	0.00	0.00
1.7.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.7.7	Бусад	0.00	0.00
1.8	Үндсэн хөрөнгө	464,484,270,540.76	473,566,293,211.13
1.9	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.10	Борлуулах зориулалттай хөрөнгө	389,139,573.48	414,487,891.10
1.11	Биет бус хөрөнгө	43,529,293,922.69	34,377,217,100.52
1.12	Нийт хөрөнгийн дүн	17,350,642,072,349.80	20,302,724,608,107.70
2	ӨР ТӨЛБӨР		
2.1	Харилцах	4,490,351,136,888.14	5,007,554,265,245.24

2.1.1	Харилцах дансны нэрлэсэн үлдэгдэл	4,490,351,136,888.14	5,007,554,265,245.24
2.1.2	Харилцах дансанд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	0.00	0.00
2.2	Хадгаламж	7,638,617,568,980.25	8,891,415,790,781.43
2.2.1	Хугацаагүй хадгаламж	1,690,588,384,715.56	2,167,802,131,034.83
2.2.2	Хугацаатай хадгаламж	5,641,377,072,755.67	6,481,848,611,390.16
2.2.3	Бусад төрлийн хадгаламж	129,507,227,086.18	810,000,000.00
2.2.4	Хадгаламжинд хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	177,144,884,422.84	240,955,048,356.44
2.3	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	2,417,172,739,165.79	2,669,966,881,192.33
2.3.1	Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан харилцах, хадгаламж	435,312,086,998.64	314,086,546,077.81
2.3.2	Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл (хугацаа хэтэрсэн зээлийн дүнг оруулсан)	1,940,677,492,772.24	2,320,627,795,268.83
2.3.3	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-11,914,296,047.89	(11,706,739,138.22)
2.3.4	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	53,097,455,442.80	46,959,278,983.91
2.4	Бусад эх үүсвэр	444,611,686,238.96	1,019,855,687,521.85
2.4.1	Банкнаас гаргасан өрийн бичиг	53,876,315,000.00	35,912,625,000.00
2.4.2	Банкнаас гаргасан үнэт цаас	221,641,400,000.00	752,353,750,000.00
2.4.3	Төслийн зээлийн санхүүжилт	77,414,762,111.73	81,041,535,593.75
2.4.4	Буцаан худалдан авах нөхцөлөөр худалдсан үнэт цаас (репо)	60,182,082,018.84	87,791,865,061.06
2.4.5	Хамтын зээлжүүлэлтийн эх үүсвэр	0.00	0.00
2.4.6	Бусад	27,619,436,512.37	55,156,905,564.60
2.4.7	Бусад эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр	-2,290,267,923.87	(6,428,107,647.63)
2.4.8	Бусад эх үүсвэрт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	6,167,958,519.89	14,027,113,950.07
2.5	Дериватив санхүүгийн өр төлбөр	721,212,990.00	0.00
2.6	Бусад санхүүгийн өр төлбөр	185,222,890,984.49	164,706,715,084.30
2.7	Бусад санхүүгийн бус өр төлбөр	82,209,478,725.80	84,567,020,937.35
2.8	Хоёрдогч өглөг	0.00	0.00
2.9	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)	0.00	0.00
	Нийт өр төлбөрийн дүн	15,258,906,713,973.40	17,838,066,360,762.50
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	191,219,800,000.00	191,219,800,000.00
3.1.1	Давуу эрхийн хувьцаа	0.00	0.00
3.1.2	Энгийн хувьцаа	191,219,800,000.00	191,219,800,000.00
3.2	Нэмж төлөгдсөн капитал	164,257,808,200.00	164,257,808,200.00
3.3	Халаасны хувьцаа	0.00	0.00
3.4	Дахин үнэлгээний нэмэгдэл	86,182,451,827.22	84,328,874,854.19
3.5	Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,649,038,590,069.83	2,018,390,801,117.22
3.6	Бусад өөрийн хөрөнгө	1,036,708,279.28	6,460,963,173.84
3.6.1	Хувьцааны опцион	0.00	0.00
3.6.2	Нөөцийн сан	0.00	0.00
3.6.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сан	0.00	0.00
3.6.4	Эрсдэлийн сангийн нөөц	0.00	0.00
3.6.5	Нийгмийн хөгжлийн сан	0.00	0.00
3.6.6	Хөрвөх өр төлбөр	0.00	0.00
3.6.7	Хувьцааны баталгаа бүхий зээл	0.00	0.00
3.6.8	Бусад	1,036,708,279.28	6,460,963,173.84
3.7	Өөрийн хөрөнгийн дүн	2,091,735,358,376.33	2,464,658,247,345.25
4	Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн	17,350,642,072,349.80	20,302,724,608,107.80

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН			
Төгрөгөөр			2024/12/31
	Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Хүүгийн орлого	2,052,185,427,491.23	2,553,680,935,641.85
1.1	Монголбанкинд байршуулсан хөрөнгийн	74,959,186,129.04	37,672,814,573.20
1.2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	9,932,865,476.22	8,899,382,728.11
1.3	Үнэт цаасны	432,193,414,132.68	576,803,745,148.97
1.4	Зээлийн	1,357,423,490,412.65	1,767,941,598,644.73
1.5	Бусад хүүгийн орлого	177,676,471,340.64	162,363,394,546.84
2	Хүүгийн зардал	998,485,157,774.27	1,327,175,669,551.34
2.1	Харилцахад төлсөн хүү	11,134,540,742.23	36,708,697,932.76
2.2	Хадгаламжинд төлсөн хүү	578,475,581,809.33	830,808,959,682.66
2.3	Зээлийн хүүгийн зардал	155,633,153,856.14	169,746,313,098.03
2.4	Үнэт цаасны хүүгийн зардал	28,981,270,534.07	45,604,474,203.03
2.5	Бусад хүүгийн зардал	224,260,610,832.50	244,307,224,634.86
3	Хүүгийн цэвэр орлого [(1)-(2)]	1,053,700,269,716.96	1,226,505,266,090.51
4	Эрсдэлийн сангийн зардал	85,928,621,468.68	101,665,509,802.56
4.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн	106,582,070.00	5,147,445,250.00
4.2	Үнэт цаасны	0.00	5,988,005,100.00
4.3	Зээлийн	85,822,039,398.68	90,530,059,452.56
5	Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого [(3)-(4)]	967,771,648,248.28	1,124,839,756,287.95
6	Бусад орлого	472,189,685,708.19	464,947,315,337.56
6.1	Хүүгийн бус орлого	457,596,273,845.04	448,918,871,250.67
6.1.1	Арилжааны орлого	64,518,893,737.39	56,255,864,794.90
6.1.2	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	77,722,352,301.57	56,625,505,207.29
6.1.3	Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	315,355,027,806.08	336,037,501,248.48
6.1.4	Бусад хүүгийн бус орлого	0.00	0.00
6.2	Бусад орлого, олз	14,593,411,863.15	16,028,444,086.89
7	Бусад зардал	697,203,015,848.74	759,855,586,780.00
7.1	Хүүгийн бус зардал	686,787,833,393.09	746,049,866,324.68
7.1.1	Бусад эрсдэлийн сангийн зардал	4,451,712,761.65	12,684,500,238.29
7.1.2	Арилжааны зардал	38,538,526,620.67	24,906,761,288.71
7.1.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	83,267,273,092.32	56,159,021,656.75
7.1.4	Хураамж, шимтгэлийн зардал	38,269,699,500.32	46,221,390,223.35
7.1.5	Үйл ажиллагааны бусад зардал	522,260,621,418.13	606,078,192,917.58
7.2	Бусад зардал, гарз	10,415,182,455.65	13,805,720,455.32
8	Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)	742,758,318,107.73	829,931,484,845.51
9	Орлогын татварын зардал	183,975,449,096.69	191,417,028,231.15
10	Татварын дараах ашиг, алдагдал (8-9)	558,782,869,011.04	638,514,456,614.36
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал		0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)	558,782,869,011.04	638,514,456,614.36
13	Бусад дэлгэрэнгүй орлого	12,707,700,092.74	3,570,677,921.53
13.1	Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны өсөлт, бууралт	(2,201,644,998.35)	(1,853,576,973.03)
13.2	Борлуулахад бэлэн үнэт цаасны дахин үнэлгээний өсөлт, бууралт		
13.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн сангийн өсөлт, бууралт		
13.4	Эрсдэлийн сангийн нөөцийн өсөлт, бууралт		
13.5	Бусад	14,909,345,091.09	5,424,254,894.56
14	Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (10+11)	571,490,569,103.78	642,085,134,535.89

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр								2024/12/31
	Өөрийн хөрөнгийн зүйл	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Нэмж төлөгдсөн капитал	Халаасны хувьцаа	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	172,097,820,000.0	0.0	0.0	88,384,096,825.6	109,373,419,548.1	1,268,756,787,060.4	1,638,612,123,434.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							0.0
3	Залруулсан үлдэгдэл	172,097,820,000.0	0.0	0.0	88,384,096,825.6	109,373,419,548.1	1,268,756,787,060.4	1,638,612,123,434.1
4	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	558,782,869,011.0	558,782,869,011.0
5	Бусад дэлгэрэнгүй орлого					(108,336,711,268.9)		(108,336,711,268.9)
6	Өмчид гарсан өөрчлөлт	19,121,980,000.0	164,257,808,200.0					183,379,788,200.0
7	Хуваарилсан ногдол ашиг	0.0		0.0	0.0	0.0	(180,702,711,000.0)	(180,702,711,000.0)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	(2,201,644,998.4)		2,201,644,998.4	0.0
9	2023 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	191,219,800,000.0	164,257,808,200.0	0.0	86,182,451,827.2	1,036,708,279.3	1,649,038,590,069.8	2,091,735,358,376.3
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							0.0
11	Залруулсан үлдэгдэл	191,219,800,000.0	164,257,808,200.0	0.0	86,182,451,827.2	1,036,708,279.3	1,649,038,590,069.8	2,091,735,358,376.3
12	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	0.0	0.0	0.0	0.0	638,514,456,614.4	638,514,456,614.4
13	Бусад дэлгэрэнгүй орлого					5,424,254,894.6		5,424,254,894.6
14	Өмчид гарсан өөрчлөлт							0.0
15	Хуваарилсан ногдол ашиг	0.0		0.0	0.0	0.0	(271,015,822,540.0)	(271,015,822,540.0)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	0.0	(1,853,576,973.0)		1,853,576,973.0	0.0
17	2024 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл	191,219,800,000.0	164,257,808,200.0	0.0	84,328,874,854.2	6,460,963,173.8	2,018,390,801,117.2	2,464,658,247,345.3

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН			
Төгрөгөөр			2024/12/31
	Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
1.1	Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	742,758,318,107.73	830,231,484,845.51
1.2	Орлого, зардлын тохируулга:	-800,165,567,911.19	-1,013,578,240,916.08
1.2.1	Эрсдэлийн сангийн зардал (+)	90,380,334,230.33	114,350,010,040.85
1.2.2	Элэгдэл, хорогдлын зардал (+)	73,969,317,571.28	74,200,806,869.55
1.2.3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (-), зардал (+) (Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөөс бусад)	10,927,128,197.95	7,616,282,920.38
1.2.4	Хуримтлуулсан хүүгийн орлого (-)	-2,052,185,427,491.23	-2,553,680,935,641.85
1.2.5	Хуримтлуулсан хүүгийн зардал (+)	998,485,157,774.27	1,327,175,669,551.34
1.2.6	Хөрөнгө данснаас хассаны олз (-), гарз (+)	73,081,393.07	90,005,200.14
1.2.7	Бусад олз (-), гарз (+)	78,184,840,413.14	16,669,920,143.51
1.3	Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	-39,648,177,498.17	-906,102,404,633.75
1.3.1	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	-136,412,532,763.73	-542,122,137,402.76
1.3.2	Арилжааны үнэт цаасны өсөлт (-), бууралт (+)	0.00	0.00
1.3.3	Зээлийн өсөлт (-), бууралт (+)	-1,669,169,674,800.17	-2,238,888,156,632.27
1.3.4	Бусад санхүүгийн хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	-4,142,287,520.48	-42,525,477,725.50
1.3.5	Бусад санхүүгийн бус хөрөнгийн өсөлт (-), бууралт (+)	-32,234,571,610.89	-43,456,079,104.94
1.3.6	Харилцах, хадгаламжийн өсөлт (+), бууралт (-)	1,348,538,454,031.45	1,706,191,186,224.68
1.3.7	Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (+), бууралт (-)	417,508,644,304.91	258,932,318,485.43
1.3.8	Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	11,246,161,750.39	-22,999,099,530.70
1.3.9	Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (+), бууралт (-)	25,017,629,110.35	18,765,041,052.30
1.4	Бусад тохируулга:	960,611,236,296.92	1,068,622,586,328.40
1.4.1	Авсан хүү (+)	2,019,999,765,367.31	2,545,960,169,525.25
1.4.2	Төлсөн хүү (-)	-902,953,988,301.91	-1,261,644,526,646.45
1.4.3	Орлогын татварын төлөлт (-)	-156,420,424,170.48	-207,824,527,071.90
1.4.4	Эрсдэлийн сангаас хаасан зээл, авлага (-)	-14,116,598.00	-7,868,529,478.50
1.5	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	863,555,808,995.29	-20,826,574,375.92
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-1,385,405,326.81	292,473,907,769.96
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,114,003,317.77	394,254,084.79
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.6	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.7	Борлуулахад бэлэн үнэт цаас борлуулсны орлого	0.00	0.00
2.1.8	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас борлуулсны орлого	0.00	0.00

2.1.9	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.10	Бусад мөнгөн орлого	-2,499,408,644.58	292,079,653,685.17
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-69,275,098,605.00	-74,661,218,732.66
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	53,739,014,009.63	66,837,683,245.08
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	15,536,084,595.37	7,823,535,487.58
2.2.3	Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Охин компани, хараат компани, хамтын хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Зээл ба авлага гэж ангилан хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.6	Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.7	Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.8	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.9	Бусад мөнгөн зарлага	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-70,660,503,931.81	217,812,689,037.30
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ:	***	***
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	183,379,788,200.00	567,384,845,852.71
3.1.1	Бусад эх үүсвэр татаж хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хоёрдогч өглөгөөс хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	183,379,788,200.00	0.00
3.1.4	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.5	Бусад	0.00	567,384,845,852.71
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-274,843,253,797.72	-271,015,822,540.00
3.2.1	Бусад эх үүсвэрт төлсөн	94,140,542,797.72	0.00
3.2.2	Хоёрдогч өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.4	Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн	0.00	0.00
3.2.5	Төлсөн ногдол ашиг	180,702,711,000.00	271,015,822,540.00
3.2.6	Бусад	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-91,463,465,597.72	296,369,023,312.71
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	701,431,839,465.76	493,355,137,974.09
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,192,333,285,266.04	4,893,765,124,731.80
7	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,893,765,124,731.80	5,387,120,262,705.89

1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт
------	--

ХААН Банк ХК (“ХААН Банк”, “Банк” гэх)-ийн жилийн санхүүгийн аудитаар баталгаажуулсан тайлангийн 3-9 дүгээр хуудас.	
---	--

1.2.	Аудитын тодорхойлох захидал
------	-----------------------------

Банкны жилийн санхүүгийн аудитаар баталгаажуулсан тайлангийн 3 дугаар хуудас.

2. Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл

2.1. Үйл ажиллагааны үр дүн

Нийт актив:

2024 оны эцсийн байдлаар нийт актив 20.3 их наяд төгрөгт хүрч, 2023 оны эцэстэй харьцуулахад 17.0 хувийн өсөлт үзүүлсэн ба энэ нь нийт банкны систем дэх тэргүүлэх үзүүлэлт бөгөөд 2024 оны 4-р улирлаар 28.4 хувийг эзэлж байна.

Нийт зээл:

2024 оны эцсийн байдлаар нийт зээлийн багц 11.9 их наяд төгрөгт хүрч, 2023 оны эцэстэй харьцуулахад 2.3 их наяд төгрөг буюу 23.4 хувиар өссөн.

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө:

ХААН Банкны нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 17.4 хувь буюу 2.6 их наяд төгрөгөөр өсөж, 17.6 их наяд төгрөгт хүрлээ. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн 81 хувийг харилцагчаас татсан эх үүсвэр, 19 хувийг банк, санхүүгийн байгууллагаас татсан зээллэг болон бусад эх үүсвэр бүрдүүлж байна.

Өөрийн хөрөнгө:

Нийт өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны эцсээс 17.8 хувь буюу 372.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 2.5 их наяд төгрөгт хүрсэн байна.

Ашигт ажиллагаа:

2024 оны эцсийн байдлаар ХААН Банк 638.5 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллалаа. Үүнээс хүүгийн цэвэр орлого 1,259.7 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 172.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүллээ. Активын өгөөж 3.4 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 28.9 хувьтай байна.

2.2. Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт

2024 оны 12 сарын 31-ний байдлаар Монголбанкны зохистой харьцаа үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ(>12%)

Нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээ өмнөх оны эцсээс 0.9 пунктээр буурч 17.77 хувьд хүрлээ.

I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ (>13%)

I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ өмнөх оны эцсээс 0.9 пунктээр буурч 17.77 хувьд хүрлээ.

Хөрвөх чадварын харьцаа(>25%)

Банкны хөрвөх чадварын харьцаа 44.5 хувь буюу зохистой харьцаа 25 хувиас дээш байх шалгуурыг бүрэн хангаж ажиллалаа.

Зээлийн чанар

Чанаргүй зээлийн багц 516.5 тэрбум төгрөг буюу нийт зээлд эзлэх хувь 4.3 хувь болж, өмнөх оны эцсээс 0.95 пунктээр буурлаа.

	2023	2024
Ашигт ажиллагаа		
Өөрийн хөрөнгийн өгөөж	31.7%	28.9%
Активын өгөөж	3.5%	3.4%
Зардал орлогын харьцаа	40.2%	40.9%

Зээлийн чанар			
Чанаргүй зээлийн харьцаа		5.3%	4.3%
Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа		127.9%	142.3%
Монголбанкны шалгуур			
Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа (>12%)		18.6%	17.8%
1-р зэрэглэл өөрийн хөрөнгийн харьцаа (>13%)		18.6%	17.8%
Хөрвөх чадварын харьцаа (>25%)		46.5%	44.5%
Нэгж гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+-15%)		-6.3%	-2.8%
Нийт гадаад валютын нээлттэй позицын харьцаа (+-30%)		-6.5%	-3.1%

2.3.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл

Олон улсад үргэлжилж буй Геополитикийн тодорхойгүй байдал түүнийг дагасан эрсдэл, АНУ, БНХАУ-ын худалдааны дайны нөхцөл байдал зэрэг нь нийлүүлэлтийн сүлжээ тасалдах, чингэлгийн тээврийн зардал өсөх, шатахуун, улаан буудай, эрчим хүч зэрэг чухал импортын бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдэхэд нөлөөлсөн. 2024 оны хувьд дэлхий даяар сонгуулийн жил тохиож, бодлогын өөрчлөлтүүдийг тойрсон тодорхой бус байдлыг нэмэгдүүлсэн хэдий ч дэлхийн эдийн засаг 2.8 хувиар өссөн ба бүс нутгийн хувьд харилцан адилгүй өсөлтийг үзүүлсэн байна.

2024 оны эхнээс дэлхийн эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, түүхий эдийн эрэлт өссөний улмаас зэс болон төмрийн хүдэр зэрэг голлох түүхий эдийн үнэ олон улсын зах зээлд дахин өссөн. Уул уурхайн сэргэлт дагасан тээвэр, худалдаа үйлчилгээний салбарын өсөлт нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлж, Монгол улсын бодит эдийн засаг 4.9 хувиар өсөж нэрлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүн 80.0 их наяд төгрөгт хүрсэн. Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой цаг агаарын гэнэтийн хүндрэл, зудын нөхцөл байдал өвлийн саруудад ихэнх аймгуудад үүссэн ба хөдөө аж ахуйн салбарт тулгарсан энэхүү хүндрэл нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлсөн бол эдийн засгийн идэвхжил, төсвийн тэлэх бодлогын нөлөөгөөр дотоод эрэлт нэмэгдсэнээр инфляцын түвшин өсөж оны эцэст 9.0 хувьд хүрлээ.

2024 оны 6 сард УИХ-ын сонгууль болж, нэгдсэн эвслийн Засгийн газар байгуулагдсан ба эдийн засгийг тэлэх 14 мега төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөн улсын төсөвт тусгасан нь цаашдын эдийн засгийн тулгуур хүчин зүйлсийг өдөөх хүчин зүйл болсон. Мөн төрөөс баримталж буй бодлого, чиглэлүүд цахим шилжилтийг дэмжиж эрчимжүүлэхэд түлхэц болж байгаа тул бизнесийн бүхий л салбарт цахим шилжилт хурдацтай явагдаж байна. Цахим хэрэглээ өсөхийн хэрээр нийгэмд гарч буй сөрөг хандлага, нийт массыг хамарсан сошиал давлагаа зэрэг нь иргэдийн суурь боловсрол, санхүүгийн боловсрол зэргийг сайжруулах шаардлагатай суурь хүчин зүйл болж байна.

Дэлхийн банкнуудын хөгжлийн тэргүүн чиглэлүүдийн нэгэн адил Монголын банкнуудын голлох өрсөлдөөн цахим шилжилт ба хиймэл оюун суурьтай бизнес модель хөгжүүлэлтийн хүрээнд явагдаж байна. Банкнууд харилцагчийн туулах замыг хялбаршуулж, Супер апп, цахим хэтэвчийг нэвтрүүлж, дата аналитик, хиймэл оюунд суурилан харилцагчийн үйлчилгээг сайжруулж, GenAI суурьтай чатбот зэрэг шинэ технологиудыг ашиглаж эхлээд байна. Бизнесийн орчны хөгжлийг даган зайлшгүй хийгдэх суурь хөгжүүлэлтүүд болох үндсэн системүүдийн шинэчлэлт, арын үйл ажиллагааг автоматжуулах RPA, BPA зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхээс гадна цахим шилжилтийн салшгүй хэсэг болсон ажилтнуудын цахим ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлд илүүтэй анхаарах замаар дэлхийн тренд дагасан цахим банк болох, нээлттэй банк болох чиглэлүүд рүү ажиллаж байна.

Цахим шилжилтийн нөлөөгөөр харилцагчийн сонголт, үнэнч байдал, хэрэглээний чиг хандлага хувьсан өөрчлөгдөж, харилцагч банкнуудын голлох үзүүлэлтүүдээс гадна төлбөр тооцоо хийхэд системийн өдөр тутмын найдвартай байдал, уян хатан бүтээгдэхүүний нөхцөл, хэрэглэхэд хялбар, ойлгомжтой аппликейшн болон интернэт банк, урамшуулалт хөтөлбөр, лоялти зэргийг чухалчилж байна. Хэдийгээр иргэдийн зах зээлд дээрх цахимжилтын тренд банкны бизнесийн моделийг өөрчилж байгаа боловч банкнууд Корпорэйт болон Жижиг дунд бизнес эрхлэгч харилцагчдадаа илүү харилцаанд суурилсан үйлчилгээг санал болгох, харилцагчдадаа ойр салбар нэгжийн оновчтой зохион байгуулалт хийх, Менежментийн болон бусад зөвлөх үйлчилгээг үзүүлэх, Бизнес эрхлэгчдийг хооронд нь холбох, харилцагчаа хөгжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх чиг хандлагатай байна.

ХААН Банкны зах зээл эзлэлт 2024 оны эцсийн байдлаар системийн нийт хөрөнгийн 28.4 хувь, нийт зээлийн 32.4 хувь, харилцагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн 31.3 хувийг тус тус эзэлж системийн нөлөө бүхий банк хэвээр байна.

Банк харилцагч төвт аргачлалаас харилцагчийн туршлага төвт аргачлалд шилжиж, хялбар найдвартай цахим сувгийн туршлагыг бүх сегментийн харилцагчдадаа үзүүлэх, харилцагчийн амьдралын хэв маягт нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг хиймэл оюун, өгөгдлийн шинжилгээнд суурилан санал болгохоор зорьж байгаа ба 2024 онд IDCXS2022:02 олон улсын цахим харилцагчийн туршлагын стандартыг Төгөлдөршил түвшинд баталгаажуулан ажиллалаа. Мөн хиймэл оюунд суурилсан Digi цахим туслахыг зах зээлд амжилттай нэвтрүүлснээр харилцагчийн цагийг хэмнэх, хэрэгцээт мэдээллээ түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлсэн.

ХААН Банк Тогтвортой бизнесийн стратегийн хүрээнд тогтвортой хөгжлийг дэмжсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр болон сайжруулан нэвтрүүлэхээс гадна тогтвортой хөгжлийн бодлого, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ авах чиглэлд олон улсын байгууллагуудын зөвлөх үйлчилгээг авч суурь хөрөнгө оруулалтыг хийсээр байна. Мөн Ногоон технологийн шалгуур хангасан бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэгч бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг нэг дор багтаасан www.green.khanbank.com онлайн платформыг нэвтрүүллээ. Жижиг дунд бизнесийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, ногоон зээл, эмэгтэй бизнес эрхлэгчдийн зээлийг нэмэгдүүлэх, ХАА-ын ноолуур, үр тариа, сүү, махны кластерыг хөгжүүлэхэд чиглэсэн тухайлсан бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлэхийн сацуу жижиг дунд бизнес эрхлэгчдэд хэрэгцээт санхүүгийн болон санхүүгийн бус бүхий л үйлчилгээг нэг дороос, шуурхай хүргэх зорилготой “Бизнес төв”-ийг Улаанбаатар хотод 18, орон нутагт 21 аймагт байгууллаа. Мөн бизнес эрхлэгчдэд гадаад гүйлгээг түргэн шуурхай хийх боломж бүрдүүлж АНУ-д төвтэй олон улсын нэр хүнд бүхий The Bank New York Mellon (BNY Mellon) банканд ам.долларын дансаа нээлээ.

Цахим стратегийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, цахим төлбөр тооцооны экосистемийг хөгжүүлэх зорилгоор иргэн болон байгууллагын харилцагчдад зориулсан төлбөр тооцооны шинэ боломжит шийдлүүдийг нэвтрүүлсээр байна. 2024 онд харилцагчийн төлбөр тооцоог хялбарчлах, шимтгэлгүй, урамшуулалтай, цорын ганц дахин давтагдашгүй Digitag үүсгэж гүйлгээ хийх боломжтой, DigiPay-г амжилттай нэвтрүүлсэн ба тайлант хугацаанд 240 мянга гаруй харилцагчтай болсон. Мөн олон улсын цахим төлбөр, дижитал технологийн шийдэл нэвтрүүлэгч Alipay-тэй хамтран дэлхийн 12 улсын цахим хэтэвч хэрэглэгчдийн төлбөрийг ХААН Банкны ПОС төхөөрөмжид хүлээн авдаг болсон. Бизнесийн харилцагчдад чиглэсэн гар утасны NFC-ээр дамжуулан зайнаас унших технологийг ашиглан хэзээ ч хаана ч төлбөр тооцоогоо хялбар хүлээн авах боломжтой DigiPOS аппликэйшнийг нэвтрүүлсэн ба 2024 оны эцсээр 15 мянга гаруй картаар үйлчлэгч байгууллагатай болсон байна. Харилцагчдадаа шинэ шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх зорилгоор 2024 онд картын рэбрэндингийг хийж Монголын анхны LED гэрэлтэй төлбөрийн карт - Парис 2024, Easy Кредит карт, Монголын анхны хөдөлгөөнт виртуал карт болох Digi карт, Алтан гэрэгэнээс сэдэвлэсэн “SplendorPlus” ЮнионПэй алтан карт зэргийг шинээр нэвтрүүллээ.

2024 онд ХААН Банк 2024-2026 оны дунд хугацааны Тогтвортой бизнесийн стратегийг үндсэн 4 тулгуур чиглэлийн хүрээнд тодорхойлсон ба Тогтвортой Хөгжлийн бодлоготой нягт уялдаж, Тогтвортой хөгжлийн 17 зорилтыг цогцоор нь стратегийн хувьд дэмжиж, НҮБ-ын Глобал гэрээний зарчмуудыг тууштай баримталж, үйл ажиллагааны бүх чиглэлд илүү тогтвортой, хүртээмжтэй ирээдүйд үнэ цэн оруулахуйц зорилт бүхий стратеги юм.

Харилцагчийн туршлагыг сайжруулах чиглэлд хялбар, шуурхай, найдвартай цахим сувгийн туршлагыг бүх сегментийн харилцагчдад хүргэж, үр дүнтэй түншлэл болон манлайллаар дамжуулан оролцогч талуудын харилцаа холбоог хангах, харилцагчийн асуудлыг шийдвэрлэх хамгийн сайн процессыг олон улсын хэрэглэгчийн туршлагын стандартын дагуу хэрэгжүүлэх, хиймэл оюунд суурилсан чатбот ашиглан санхүүгийн боловсрол, зөвлөгөө олгож хамгийн сайн харилцагчийн үйлчилгээг бий болгох, бүх сегментэд чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулж, өгөгдлийн ашиглалт, машин сургалтад суурилж харилцагчдад тохирсон бүтээгдэхүүнийг санал болгох стратегийг тэргүүн чиглэл болгож байна.

Бизнесийн өсөлтийг хангах чиглэлд зээлийн багцыг тэнцвэртэй өсгөх, тогтвортой санхүүжилтийг дэмжсэн ногоон зээлийг нэмэгдүүлэхэд голлон анхаарах ба эрсдэлийн удирдлагыг олон улсын жишигт нийцүүлэн хэрэгжүүлж, бизнесийн үйл ажиллагаанд “СТОУС S1 & S2, ICAAP, ILAAP” зэрэг санхүүгийн болон эрсдэлийн удирдлагын олон улсын стандартыг хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгаралтыг хэмжиж ил тод болгох, Кибер эрсдэл, уур амьсгалын эрсдэл, биет эрсдэл, шилжилтийн эрсдэл зэрэгт онцгой анхааран байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Цахим стратегийн хүрээнд цахим худалдааны төлбөр тооцооны туршлагыг хялбарчилж, цахим хэтэвч ба цахим төлбөр тооцооны дэд бүтцийг хөгжүүлэх, харилцагчийн амьдралын хэв маяг болон бизнесийн үйл ажиллагаанд зориулсан төлбөр тооцооны экосистемийг бүрдүүлж иргэн ба бизнесийн харилцагчдад санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шилдэг техник технологийн үйлчилгээгээр хангах зорилттой. Түүнчлэн орчин үеийн технологийг хөшүүрэг болгож роботжуулсан ба бизнес процесс автоматжуулах технологи, кодгүй, бага код бүхий хөгжүүлэлтийн платформ зэргийн тусламжтайгаар банкны хэмжээнд үйл ажиллагааг автоматжуулж үр ашгийг нэмэгдүүлэх стратеги зорилтыг тавьсан.

Байгууллагын хөгжлийг дэмжсэн зорилтын хүрээнд ХААН Банкны тогтвортой хөгжлийн бодлогыг ТХЗ ба ҮТХН-тэй нийцүүлэн өргөжүүлж, БОНЗ-ын тэргүүлэх чиглэл ба үзүүлэлтүүдэд хэмжигдэхүйц зорилтыг тогтооно. Хүний нөөцийн хувьд ажилтны туршлага, ажлын эерэг орчин, сэтгэл ханамж, хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдалд анхаарч тэргүүний ажил олгогч байр сууриа хадгалах, ажилтны цахим сэтгэлгээ, өгөгдлийн ашиглалтыг тасралтгүй хөгжүүлж, ажилтны бүтээмжийг сайжруулж бизнесийн амжилтад хүрэх тогтвортой хүний нөөцийн туршлагыг хэрэгжүүлэхээр зориод байна.

2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл	Банкны жилийн санхүүгийн аудитлагдсан тайлангийн 66-74 дүгээр хуудас
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	

Тайлант хугацаанд буюу 2024 онд нийт 331.25 сая ам.долларын дүн бүхий санхүүжилтийг урт хугацаат, барьцаагүй зээл болон өрийн хэрэгсэл хэлбэрээр татан төвлөрүүлсэн. Тайлант хугацаанд татан төвлөрүүлсэн санхүүжилтээс эргэн төлөлт хийгдээгүй болно. 2024 оноос өмнөх жилүүдэд татан төвлөрүүлсэн нийт

санхүүжилтийн эргэн төлөлтийн дүн 89.7 сая ам.доллар болно. 2024 оны эцсийн байдлаар санхүүжилтийн нийт үлдэгдэл 809.5 сая ам.доллар байна.

3. Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл

Банк нь сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг холбогдох хууль тогтоомж болон 2024 оны 2 сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар шинэчилж, 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр өөрчлөлт оруулсан “Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон Их хэмжээний хэлцэл хийх бодлого”-д нийцүүлэн байгуулдаг болно.

2024/12/31

сая төгрөгөөр

Банкны холбогдох этгээд (Нэгдмэл сонирхолтой этгээд)		Активын хэлбэр	Үлдэгдэл дүн	Өөрийн хөрөнгийн эзлэх хувь
1	Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй)			
1.1	Банкны хувьцаа эзэмшигч*	Зээл/баталгаа	41,032.4	1.66%
1.2	Банкны эрх бүхий албан тушаалтан*	Зээл	4,585.0	0.19%
1.3	Банкны бусад холбогдох этгээд*	Зээл/баталгаа	19,136.3	1.99%
2.	Банкны нийт холбогдол этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй)			
2.1	Банкны нийт хувьцаа эзэмшигчид	Зээл/баталгаа	41,032.4	1.66%
2.2	Банкны эрх бүхий албан тушаалтнууд	Зээл	11,717.1	0.48%
2.3	Банкны бусад холбогдох этгээд	Зээл/баталгаа	49,136.3	1.99%

* - Банкны холбогдох нэг этгээд (Банкны хувьцаа эзэмшигч, банкны эрх бүхий албан тушаалтан, эсвэл банкны бусад холбогдох этгээд)-эд олгосон хамгийн өндөр дүнтэй зээл болон зээлтэй адилтган тооцох актив хөрөнгийн дүнг тайлагнана.

ХААН Банк нь тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгээгүй болно.

4. Цалин урамшууллын мэдээлэл

ХААН Банкны Хүний нөөцийн бодлогын 4 дүгээр бүлэгт цалин хөлсний бүтэц, үндсэн цалин ба түүний хэмжээг тогтоох, хэрхэн нэмэгдүүлэх талаар тусгасан. Тус бүлэгт Монголын банкны системийн өрсөлдөөнт нөхцөл байдлыг харгалзан ХААН Банк нь бусад өрсөлдөгч банкны ажилтнууддаа олгож буй цалингийн түвшинтэй дүйцэхүйц, тэдгээрээс арай өндөр түвшинд цалин хөлс тогтоохыг эрмэлзэхээр заасан. Түүнчлэн үндсэн ажилтны цалингийн хэмжээг тогтоохдоо гадаад зах зээлийн цалингийн түвшин, албан тушаалын түвшин, зэрэглэл, ажилтны ур чадвар, мэргэшсэн байдал, гадаад хэлний мэдлэг, банкны бизнесийн хэрэгцээ, эдийн засгийн боломж болон инфляц, амьжиргааны өртгийн түвшин зэргийг харгалзан үзнэ.

Банкны Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ” гэх)-өөр батлагдсан санхүүгийн болон санхүүгийн бус бизнес зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэдэг. Эдгээр бизнес зорилтуудын хэрэгжилтийг ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо улирал тутам хянаж, Банкны

жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан гарсны дараа тайлант жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хийдэг.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооноос Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Цалин урамшууллын хорооноос гаргасан саналын дагуу ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагад олгох үндсэн цалин, урамшууллын хэмжээг тогтоодог. Ийнхүү тогтоохдоо ХААН Банкны Цалин хөлсний журмын дагуу дараах зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрддөг. Үүнд:

1. Эрх тэгш, шударга байх;
2. Өрсөлдөхүйц байх;
3. Хуульд нийцсэн байх;
4. Цалин хөлс олгох ажиллагаа ил тод байх;
5. Нууцлалтай байх;
6. Ажлын байрны зэрэглэл, гүйцэтгэлд нийцтэй байх.

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

ХААН Банк нь компанийн засаглалтай холбоотой Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, сайн туршлагуудыг дотооддоо нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд анхаарч ажилладаг. Ингэснээр олон улсын үнэлгээний агентлагуудын дунд компанийн үнэлгээг өсгөх, Монголдоо системийн нөлөө бүхий тэргүүлэгч банкны нэр хүндийг хадгалахаас гадна өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэр татах, урт хугацаанд тогтвортой хөгжихөд ач холбогдолтой юм.

Олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хувьд бид олон улсын сайн туршлагаас суралцан засаглалын тогтолцоогоо тасралтгүй сайжруулан, холбогдох хууль, дүрэм журмуудын хэрэгжилтийг хангаж компанийн засаглалаар тэргүүлсэн, үлгэр жишээ компани болохыг зорьж байна.

Банк нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг бөгөөд жил бүр зохицуулагч байгууллагууд болох Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороонд (СЗХ) зохистой засаглалыг хэрэгжилтийн тайланг хүргүүлж, зохих үнэлгээ авдаг.

ХААН Банкны Компанийн засаглалын кодексийн дагуу Банк нь дараах компанийн засаглалын 4 үндсэн зарчмыг баримталдаг. Үүнд:

- Хариуцлагатай байдал – Банк хууль ёсныхоо эрх ашгийн хүрээнд өөрт олгогдсон хэрэгжүүлж буй эрх мэдэл болон үүргээ бүрэн хариуцах хариуцлагатай байх
- Ил тод байдал – Мэдээллийн нээлттэй, хүртээмжтэй, тодорхой байдлыг хангаж, оролцогч талуудад шийдвэр, үйл ажиллагааг ойлгож, итгэх боломжийг олгох
- Тайлагнал – Банкны бүх оролцогч /сонирхогч талуудад албан ёсны баримт бичиг, мэдэгдэл, харилцаагаар дамжуулан мэдээллийг тодорхой зохион байгуулалттайгаар хүргэх
- Шударга байдал – Банкны бүх оролцогч болон сонирхогч талуудад шударга, тэгш, ялгаваргүй хандах

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭ

ХААН Банк нь компанийн засаглалаа хэрхэн сайжруулж, бэхжүүлэх талаар хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, оролцогч талуудтай байнга зөвлөлдөж, мэдээлэл солилцон шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллаж байна. Компанийн тухай хууль, 2022 онд СЗХ-оос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасан компанийн засаглалын зарчмуудын дагуу ХААН Банк нь өөрийн засаглалын үнэлгээг тогтмол хугацаанд хийж, СЗХ-оор хянан баталгаажуулдаг.

Банк нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг 2024 оны байдлаар СЗХ хянан баталгаажуулж 90.3 оноогоор буюу засаглал сайн, эрсдэлгүй гэж үнэлсэн нь Банк компанийн засаглалын чанараа сайжруулж, хяналт, удирдлагын тогтолцоог илүү үр дүнтэй хэрэгжүүлж буйг илтгэж байна. Энэхүү үнэлгээний өсөлт нь дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлага, ёс зүйн дүрэм, удирдлагын шийдвэр гаргалтын ил тод байдлыг улам бүр бэхжүүлсний үр дүн юм. Цаашид бид компанийн засаглалын тогтолцоог улам сайжруулах, харилцагч болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр тасралтгүй анхаарч ажиллах зорилт тавиад байна.

Засаглалын бодлого, журмууд

1. Банкны Дүрэм
2. Банкны Компанийн засаглалын кодекс
3. Банкны Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
5. Засаглал, Цалин урамшууллын хорооны дүрэм
6. Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооны дүрэм
7. Эрсдэлийн хорооны дүрэм
8. Аудитын хорооны дүрэм
9. Хараат бус гишүүдийн нэр дэвшүүлэх журам
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ажлын албаны үйл ажиллагааны бодлого
11. Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого
12. Ногдол ашгийн бодлого
13. Дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны бодлого
14. Шүгэл үлээх бодлого
15. Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн бодлого
16. Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Компанийн тухай хуулийн 75.1, ХААН Банк ХК-ийн Дүрмийн 9.1-т заасны дагуу Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт эрх барих дээд байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь Банкны тухай хуулийн 31.3-т заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Банкны ТУЗ нь дотоодын болон дэлхийн санхүүгийн салбарт арвин туршлагатай есөн гишүүнээс бүрддэг бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгон шалгаруулдаг. 2023 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар одоогийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 3 жилийн хугацаатай томилсон. ТУЗ-ийн гишүүд Банкны тухай хуулийн 32.1-т заасан шаардлагуудыг хангасан эсэхийг Монголбанк хянан баталгаажуулдаг. Мөн, Банкны тухай хуулийн 33.1, ХААН Банк ХК-ийн Дүрмийн 9.1-т заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн 1/3 нь хараат бус гишүүд байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүрэг

- Банкны стратегийг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулах замаар асуудлыг шийдвэрлүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн баталсан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;

- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн баталсан төрөл болон тоонд багтаан Банкны дүрэмд заасан хувьцаанд хамаарахаас бусад үнэт цаас гаргах;
- Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргах;
- Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн банкны гүйцэтгэх удирдлагыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох;
- Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Банкны дотоод аудитын нэгжийг гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, гүйцэтгэх удирдлага, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
- Хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлийг тогтоох;
- Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
- Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлох;
- Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож хэрэгжилтэд хяналт тавих;
- Банкны салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- Банк өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал багтана.

Банкны ТУЗ-ийн гишүүн бүр Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Хууль, тогтоомж болон дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил, үүргээ хариуцлагатай биелүүлэх;
- Банкны эрх ашгийг хувийн болон өөрийг нь томилсон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгаас дээгүүр тавих;
- Нууцаар ашиг хүртэхгүй байх;
- Сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-д мэдээлдэг байх;
- Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх;
- Банкны Гүйцэтгэх захиралд хяналт тавих, ажлын үр дүнгийн тайланг улиралд нэгээс доошгүй удаа авч хэлэлцэх, хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах;
- Хувьцаа эзэмшигч, харилцагч болон хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалах;
- Банкны бодлого, стратеги, эрсдэл даах сонирхлыг тодорхойлох, банканд үр ашигтай шийдвэр гаргах;
- Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, банкны бүтцийн өөрчлөлт зэрэг Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавих;
- ТУЗ-өөс Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагаанд хяналт тавих, тайлагнах тогтолцоог бүрэн тусгаж, гэрээний биелэлтийг улирал бүр дүгнэх;
- Банкны удирдлагыг сонгон шалгаруулах, тэдгээрийн залгамж халааг бэлтгэх төлөвлөгөөг батлах, төлөвлөгөөнд удирдах дээд албан тушаал бүрд тавигдах ажил мэргэжлийн шаардлага, чиг үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд хангалттай түвшинд бэлтгэхийг тодорхой тусгасан байх;
- Гүйцэтгэх захирлын урамшууллын асуудлыг банкны эрхэм зорилго, урт хугацааны хэтийн зорилго, стратеги төлөвлөгөө, ёс зүйн хэм хэмжээ болон гэрээнд заасан үүргийн биелэлт зэрэгтэй уялдуулан шийдвэрлэх;
- Хууль тогтоомж болон Банкны дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай, үнэнч шударгаар гүйцэтгэж, чандлан сахих;

- Ашиг сонирхлын зөрчлийн улмаас банкны өмнө хүлээсэн үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;
- Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад заасан шаардлагыг хангасан байгууллагыг сонгон шалгаруулж, хөндлөнгийн аудит хийлгэх;
- Банкны дотоод аудитын нэгжээс хийсэн шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцэн, зохистой засаглал болон дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар Гүйцэтгэх захиралд үүрэг өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох;
- Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ мэдлэг ур чадвараа дайчлан, хичээл зүтгэл гарган ажиллах.

Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан шийдвэр нь тухайн банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх эсэхэд хяналт тавих, хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх;
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих;
- Банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах;
- Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл, холбогдох этгээдийн хэлцэл, их хэмжээний хэлцлийг хэлэлцэхэд заавал оролцож санал өгөх;
- ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн, хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн уг зөрчлийг арилгахыг холбогдох этгээдээс шаардах, шаардлагыг эс биелүүлэх тохиолдолд уг асуудлыг ТУЗ-д тавьж шийдвэрлүүлэх, улмаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шаардлагыг ТУЗ-д хүргүүлэх;
- Хувьцаа эзэмшигч, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, бодлого, шийдвэр нь банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөх, хууль тогтоомжийг зөрчих тохиолдол бүрд Монголбанканд мэдэгдэх, улмаар хүсэлт гарган банканд шалгалт хийлгэх;
- ТУЗ-ийн хараат бус гишүүн тус бүр нь өөрийн үндсэн үүргийн хэрэгжилт, ажлын тайлан зэргийг Монголбанканд болон хувьцаа эзэмшигчдийн хуралд жилд нэгээс доошгүй удаа тайлагнах;
- Аудитын болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд заавал орж ажиллах.

ТУЗ нь Банкны үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:

- ТУЗ-ийн гишүүн болон түүний төлөөлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь банканд зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн аливаа үүрэг, төлбөр нь чанаргүй ангилалд орсон тохиолдолд тус гишүүнийг ТУЗ-ийн хуралд саналын эрхтэй оролцуулах;
- Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох.

Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллах тохиолдолд ТУЗ-ийн үйл ажиллагаанд дараах байдлаар оролцохыг хориглоно:

- Аудитын хороо болон Эрсдэлийн хорооны бүрэлдэхүүнд саналын эрхтэйгээр орж ажиллах;
- Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, хариуцлагыг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих, түүний цалин урамшууллын хэмжээг тогтоох;
- Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

ТУЗ-ийн хараат бус гишүүд

- Т.Дарьбум – ТУЗ-ийн дарга

Хатагтай Т.Дарьбум 2020 оны 8 сараас ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр Монгол Улс болон Хойд Америкт бизнесийн удирдлага, банк санхүүгийн чиглэлээр 30 гаруй жил ажилласан, өндөр ур чадвартай мэргэшсэн хүн юм. Хатагтай Т.Дарьбум нь Хойд Америкийн зургаа дахь, Канад Улсын хоёр дахь том банк болох ТиДи Банк Групп-т 10 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд АНУ-ын Сиаттлийн Их

Сургуульд Санхүүгийн шинжлэх ухааны магистрын зэрэг хамгаалсан. Мэргэшсэн Нягтлан Бодогч (CPA) зэрэгтэй.

- **А.Тамир**

Монголын мэргэшсэн татварын зөвлөх, Монголын мэргэшсэн нягтлан бодогч (CPA) ноён А.Тамир нь 2020 оны 7 сараас Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр аудит, нягтлан бодох бүртгэл, татварын болон санхүүгийн тайлан, дүн шинжилгээ, бизнес төлөвлөлт гэх зэргээр зөвлөх үйлчилгээ үзүүлдэг олон улсын Пи Кэй Эф Интернэйшнл компанийн Монгол дахь гишүүн компани болох Пи Кэй Эф - Ай Эф Эс Монголиа ХХК-ийн үүсгэн байгуулагч, Ерөнхий захирлын үүргийг гүйцэтгэдэг. Ази Номхон Далайн бүсийн татварын зөвлөхүүдийн нийгэмлэгийн (АОТСА) дэд ерөнхийлөгч бөгөөд Дэлхийн татварын зөвлөхүүдийн платформын хорооны (GTAP) гишүүнээр тус тус сонгогдон ажиллаж байна.

- **Ханс Аарт Йонгеяанс**

Ноён Ханс Аарт Йонгеяанс нь 2020 оны 7 сараас Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр банк санхүүгийн салбарын эрсдлийн удирдлагын чиглэлээр 50 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд Нидерландын Вант Улсын Банк Санхүүгийн Институтийг амжилттай дүүргэн Эй Би Эн АМРО Банк (Нидерланд), Би Эн Пи Парибас Банк (Франц) мөн Австрали, Тайланд, Бельги, Саудын Араб, Бахрейн зэрэг улсуудын банк санхүүгийн байгууллагад удирдах албан тушаалд ажиллаж байсан болно.

ТУЗ-ийн ердийн гишүүд

- **Д.Хулан – ТУЗ-ийн дэд дарга**

Хатагтай Д.Хулан нь Банкны бие даасан хувьцаа эзэмшигч бөгөөд ТУЗ-ийн гишүүнээр 2003 оны 3 сараас эхлэн ажиллаж байна. Тэрээр Таван Богд Группийг үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд өдгөө ТУЗ-ийн даргын албан тушаалыг хашдаг. Хатагтай Д.Хулан нь ОХУ-ын Москва хотын Санхүүгийн Их Сургуулийг Олон улсын эдийн засгийн бакалавр зэрэгтэй, МУИС-ийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн, Япон улсад мэргэжил дээшлүүлж байсан. Мөн Монгол Улсын Сангийн Яам, Худалдаа Хөгжлийн Банк зэрэг байгууллагад ажиллаж байсан, банк санхүүгийн салбарын арвин мэдлэг, туршлагатай гишүүн билээ.

- **Иший Кисабүро**

Ноён Иший Кисабүро нь Эйч Эс Холдингс ХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд тус компанийн хараат бус захирлаар ажилладаг. Тэрээр Токиогийн их сургуулийг эрх зүйн бакалаврын зэрэгтэй төгссөн. Сургуулиа төгсмөгц ажлын гараагаа Япон Улсын Барилгын Яаманд (одоогийн Газар, Дэд Бүтэц, Тээврийн Яам) эхлүүлсэн. Тус яаманд Хотын захиргааны ерөнхий захирлаар ажиллаж байгаад Газар, дэд бүтэц, тээврийн яаманд дэд сайдын албан тушаал, Япон Улсаас Румын Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын албан тушаал хашиж байсан.

- **Ц.Баатарсайхан**

Ноён Ц.Баатарсайхан нь Таван Богд Холдингс ХХК-ийг төлөөлсөн ТУЗ-ийн гишүүн юм. Тэрээр ТУЗ-ийн ердийн гишүүнээр 2009 оны 3 сараас томилогдон ажиллаж байна. Таван Богд Группийн үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашдаг. Ц.Баатарсайхан нь Монгол Улсын Политехникийн Их Сургууль болон Япон Улсын Токио хотын Цахилгаан Холбооны Их Сургуулийг тус тус дүүргэсэн бөгөөд Монгол-Японы хамтарсан “Алтай” ХХК-ийн захирал болон МИАТ ХК-ийн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай.

- **Харада Ясүнари**

Ноён Харада Ясүнари Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед компанийг төлөөлсөн ТУЗ-ийн ердийн гишүүн бөгөөд Эйч Эс Холдингс ХК-ийн Ерөнхийлөгч, Төлөөлөгч Захирлын албан тушаалыг хашдаг. Тэрбээр Япон Улсын Кьюшү Их Сургуулийг Эрхзүйн бакалавр зэрэгтэй төгссөн. Их сургуулиа төгсмөгц тэрээр Япон Улсын Аж Үйлдвэрийн Банканд ажлын гараагаа эхлүүлсэн. Мөн Морган Стэнли, Би Эн Пи Парибас энд Социэтэ Женерале зэрэг олон улсын банкуудын Япон Улс дахь салбар банкуудад ажиллаж байсан туршлагатай.

- **Жон Ло**

Ноён Жон Ло нь байгууллагын банк болон хөрөнгө оруулалтын банкны чиглэлд 30 гаруй жил ажилласан арвин туршлагатай бөгөөд өмнө нь ОУСК-ийн Олон Улсын Санхүүгийн Зах Зээлийн газарт банкны мэргэжилтнээр ажиллаж байсны дээр СитиБанк болон Жи.Пи Морган зэрэг банкуудад Ази, Номхон Далайн бүс хариуцсан

удирдах түвшний албан тушаалууд хашиж байсан туршлагатай. Тэрбээр АНУ-ын Индиана мужийн Блүүмингтон хот дахь Индианагийн Их Сургуульд Бизнесийн удирдлагын чиглэлээр магистрын зэрэг хамгаалжээ. 2016 оноос ХААН Банкны ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

■ **Б.Амарсанаа**

Монгол Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургуулийн захирал, Хууль зүйн ухааны доктор, профессор Батболдын Амарсанаа нь Банкны ТУЗ-ийн ердийн гишүүн юм. Тэрээр өмнө нь арбитрын шүүхийн арбитрч, шүүн таслах бүрэлдэхүүний даргаар олон хэргүүд дээр ажиллаж байсан төдийгүй, Хонконгийн Олон Улсын Арбитрын Төв, Олон Улсын Худалдааны Танхимын арбитрын шүүх дээр Монгол Улсын хууль эрх зүйн мэргэжилтнээр ажиллаж маргаан шийдвэрлэж байсан туршлагатай. Үүнээс гадна Хууль Зүйн Зөвлөлийн үндсэн гишүүний хувьд Монгол Улсын томоохон хуулиудын төслийг бэлтгэх чиглэлээр ажилласан өргөн туршлагатай хүн юм.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

ТУЗ нь байгууллагын бүх шатанд ил тод, үнэнч шударга байдлыг чухалчлан, нээлттэй засаглалын зарчмыг хэрэгжүүлж, Банкны стратеги, алсын харааг тодорхойлон, Банкны үйл ажиллагааг үр ашигтай, тогтвортой байлгах зорилгоор шийдвэр гаргалт, удирдлагын процессыг чиглүүлж, дэмжин ажилладаг. Банкны ТУЗ нь Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, үүний дотор Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Монголбанк, СЗХ, Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн холбогдох дүрэм, журам, заавар, ХААН Банкны Дүрэм, Компанийн Засаглалын Кодекс, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдох эрх зүйн бичиг баримтыг мөрдөн компанийн зохистой засаглалыг хэрэгжүүлэн үйл ажиллагаа явуулдаг. ТУЗ-ийн ээлжит хурал нь жилд дөрвөөс доошгүй удаа хуралддаг бөгөөд шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ТУЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулдаг.

Тайлант хугацаанд ХААН Банкны ТУЗ нийт 9 удаа хуралдаж, 38 тогтоол баталсан. Түүнчлэн ТУЗ-ийн чиг үүргийн хүрээнд гүйцэтгэх удирдлагын багт санал, зөвлөмж өгч, үүрэг даалгавар олгон, хэрэгжилтэд нь нягт хяналт тавин ажиллалаа. Мөн 2023 оны эцэст баталсан бизнес төлөвлөгөөний дагуу сар бүр гүйцэтгэх удирдлагаас хүргүүлдэг санхүү, үр дүнгийн тайланг үндэслэн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, удирдлагын багийг оновчтой чиглүүлэн ажилласан болно.

№	Гишүүдийн нэрс	Хурлын тоо	Гишүүдийн ирц	Баталсан тогтоолын тоо
1.	Т.Дарьбум (дарга, хараат бус гишүүн)	9	100%	38
2.	Д.Хулан (дэд дарга, гишүүн)		100%	
3.	Иший Кисабүро (гишүүн)		100%	
4.	Харада Ясүнари (гишүүн)		100%	
5.	Ц.Баатарсайхан (гишүүн)		100%	
6.	Жон Ло (гишүүн)		100%	
7.	А.Тамир (хараат бус гишүүн)		97.4%	
8.	Ханс Аарт Йонгеянс (хараат бус гишүүн)		100%	
9.	Б.Амарсанаа (гишүүн)		100%	

ТУЗ-ийн 2024 онд хийсэн хурлаар хэлэлцсэн асуудлуудыг доорх хүснэгтээс харна уу.

№	Хурлаар хэлэлцсэн асуудлууд
1.	Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, эрсдэлийн удирдлагын бодлого, жилийн төсөв, бизнес төлөвлөгөөний хүрээнд: - Нийгмийн бонд /олон улсад хаалттай хүрээнд/ - “Ногоон Бондын хөтөлбөр”-т оруулсан нэмэлт - ХААН Банкны зохион байгуулалтын шинэчилсэн бүтэц - ХААН Банкны өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ICLAAP)-ын бодлого - ХААН Банкны Залилангийн удирдлагын хөтөлбөр - ХААН Банкны Тогтворжуулах төлөвлөгөө - ХААН Банкны 2023 оны “Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ICAAP)” болон “Хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ILAAP)”-ын туршилтын тайлан - 2024 оны “Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл”-д оруулсан өөрчлөлтүүд - 2025 оны Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл - 2024 оны Эрсдэлийн сангаас хорогдуулсан чанаргүй актив - 2024 оны Бизнес төлөвлөгөө - 2025 оны Бизнес төлөвлөгөө - 2025 оны Санхүүгийн төсөөлөл - 2025 оны Капитал хөрөнгийн зардал - 2025-2029 оны Дунд хугацааны санхүүгийн төсөөлөл
2.	Хувьцаа эзэмшигчид, олон улсын санхүүжилтийн хүрээнд: - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал - Хувьцаа эзэмшигчдэд хуваарилсан ногдол ашиг - Банкны тухай хуулийн 36.1-д заасан шаардлагыг биелүүлэхэд хувьцаа эзэмшигчдэд дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн төлөвлөгөө - EBRD, BOMF, COVID Fund, Германы хөрөнгө оруулалт, хөгжлийн агентлаг (DEG), OeEB, FMO Syndication зэрэг олон улсын байгууллагуудтай байгуулсан санхүүжилтийн гэрээнүүд
3.	Зохистой засаглалын хүрээнд: - Төлөөлөн удирдах зөвлөлийн хороодын шинэчилсэн бүрэлдэхүүн - Гүйцэтгэх захирлын цалин, урамшуулал - Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /шинээр томилов/ - Ерөнхий Аудитор /дахин томилов/ - Гүйцэтгэх захирал /үргэлжлүүлэн ажиллахыг зөвшөөрөв/ - Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлүүд /журмын дагуу батлав/ - ХААН Банк ХК-ийн 2023 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан - ХААН Банк ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайлан
4.	Баталсан засаглалын бодлого, журмууд: - ХААН Банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Ажлын албаны үйл ажиллагааны бодлого - ХААН Банк ХК-ийн Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого - ХААН Банк ХК-ийн Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон Их хэмжээний хэлцлийн бодлого - ХААН Банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам - ХААН Банк ХК-ийн Шүтэл үлээх бодлого - Төлөөлөн удирдах зөвлөлийн Засаглал, Цалин урамшууллын хорооны дүрэм /шинэчилсэн/ - Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хорооны дүрэм /шинэчилсэн/ - ХААН Банк ХК-ийн Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого - “ХААН Банк ХК-ийн Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийх бодлого”-д оруулсан нэмэлт, өөрчлөлт

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Компанийн тухай хуулийн 81-р зүйлд заасны дагуу Банкны ТУЗ нь тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороодыг байгуулан ажиллуулдаг. ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүрийн чиг үүрэг, үйл ажиллагаа, бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийн эрх үүрэг, тэдгээрт тавигдах шаардлага зэрэг бусад асуудлыг хороодын дүрэм, Банкны Дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар нарийвчлан зохицуулдаг. Холбогдох журам, зааврын зохистой байдлыг хадгалах үүднээс хороод нь өөрсдийн дүрмийг хянаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах саналыг ТУЗ-д хүргүүлдэг.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэг, Монголбанкнаас ирүүлсэн зөвлөмж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-т тус тус нийцүүлэн ТУЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 07 тоот тогтоолын дагуу шинэчлэн тогтоосон. Тус бүрэлдэхүүн нь 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

№	ТУЗ-ийн дэргэдэх хороод	Хорооны дарга	Хорооны гишүүд
1	Аудитын хороо	А. Тамир (хараат бус гишүүн)	Ханс Аарт Йонгеяанс (хараат бус гишүүн) Иший Кисабүро
2	Эрсдэлийн хороо	Т. Дарьбум (хараат бус гишүүн)	Ц. Баатарсайхан Ханс Аарт Йонгеяанс (хараат бус гишүүн)
3	Засаглал, Цалин урамшууллын хороо	А. Тамир (хараат бус гишүүн)	Харада Ясүнари Т. Дарьбум (хараат бус гишүүн)
4	Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо	Ханс Аарт Йонгеяанс (хараат бус гишүүн)	А. Тамир (хараат бус гишүүн) Д.Хулан

- Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Банкны санхүүгийн тайлан, тайлагналын үнэн бодит байдал, нягтлан бодох бүртгэлийн үр дүнтэй системийг хангах болон дотоод хяналтыг тогтолцоо, хэрэгжилтийг үнэлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Мөн Банкны хөндлөнгийн аудит болон дотоод аудитын мэргэжлийн, хараат бус байдал болон ажлын гүйцэтгэлд тогтмол хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж байна.

№	Гишүүдийн нэрс	Хурлын тоо	Гишүүдийн ирц	Хурлаар хэлэлцсэн асуудлууд
1.	А.Тамир (дарга, хараат бус гишүүн)	5	100% (хурал тус бүр)	Дотоод аудитын хүрээнд: - 2023 оны Дотоод Аудитын Төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан - Дотоод аудитын 2024 оны I хагас жилийн тайлан - Ерөнхий Аудиторын гүйцэтгэлийн үнэлгээ - Ерөнхий Аудиторыг дахин томилох асуудал - 2025 оны Дотоод Аудитын Төлөвлөгөө Банкны санхүүгийн тайлан, бодлого журмын хүрээнд: - “ПрайсуотерхаусКуперс Аудит” ХХК-ийн аудитласан 2023 оны Банкны санхүүгийн тайлан - ХААН Банк ХК-ийн Ашиг сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцэл хийх бодлого
2.	Ханс Аарт Йонгеяанс (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
3.	Иший Кисабүро (гишүүн)		100% (хурал тус бүр)	

- Эрсдэлийн хороо

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо нь Банкны эрсдэлийг зохистой удирдах, эрсдэлийн хяналтын системд үнэлэлт өгч, Банкны эрсдэлийн бодлогуудыг хянан батлах, учирч болзошгүй эрсдэлийн өсөлт, хязгаарын тоон үзүүлэлт дээр үндэслэн зээл, зах зээл, хөрвөх чадвар, үйл ажиллагаа, комплаенс, нэр хүнд болон бусад эрсдэлд хяналт тавих, санал зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

№	Гишүүдийн нэрс	Хурлын тоо	Гишүүдийн ирц	Хурлаар хэлэлцсэн асуудлууд
1.	Т.Дарьбум (дарга, хараат бус гишүүн)	4	100% (хурал тус бүр)	Эрсдэлийн хяналтын хүрээнд: - ХААН Банкны Тогтворжуулах төлөвлөгөө - 2024 оны “Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл”-д оруулсан өөрчлөлт - 2025 оны Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл - 2024 оны зээлийн эрсдэлийн хязгаар - 2024 оны зээлийн бус эрсдэлийн хязгаар: - Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл - Стратегийн эрсдэл - Эрсдэлийн сангаас хорогдуулсан чанаргүй актив Эрсдэлийн удирдлагын бодлого, тайлангийн хүрээнд: - ХААН Банкны өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ICLAAP)-ын бодлого - Залилангийн удирдлагын хөтөлбөр - ХААН Банкны 2023 оны “Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ICAAP)” болон “Хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ILAAP)”-ын туршилтын тайлан - “ПрайсУотерхаусКуперс Аудит” ХХК-ийн “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, санхүүгийн гэмт хэргийн технологийн системийн үнэлгээ”-ний тайлан - 2024 оны Комплаенсийн тайлан
2.	Ханс Аарт Йонгеянс (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
3.	Ц.Баатарсайхан (гишүүн)		100% (хурал тус бүр)	

- Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо

ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх, Хүний нөөцийн хороо нь Банкны хүний нөөцийн стратеги, төлөвлөгөө, үндсэн бодлого, залгамж халаа, удирдлагын гэнэтийн бэлэн байдлыг удирдах, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-өөс томилогддог эрх бүхий албан тушаалтныг нэр дэвшүүлэх, томилох, үйл ажиллагаа, ажлын гүйцэтгэлд үнэлэлт дүгнэлт өгөхөд ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

№	Гишүүдийн нэрс	Хурлын тоо	Гишүүдийн ирц	Хурлаар хэлэлцсэн асуудлууд
1.	Ханс Аарт Йонгеянс (дарга, хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	Хүний нөөцийн стратегийн хүрээнд: - ХААН Банкны зохион байгуулалтын шинэчилсэн бүтэц - Банкны нийт ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх санал - Хүний нөөцийн 2023 оны гүйцэтгэлийн тойм

2.	А.Тамир (хараат бус гишүүн)	6	100% (хурал тус бүр)	- Хүний нөөцийн 2024 оны гүйцэтгэлийн тойм Гүйцэтгэлийн үнэлгээ, нэр дэвшүүлэх хүрээнд: - Гүйцэтгэх захирлын 2023, 2024 оны ажлын гүйцэтгэлийн үнэлгээ - Гүйцэтгэх захирлыг үргэлжлүүлэн ажиллуулах - Хөдөлмөрийн гэрээг сунгах тухай - 2024 оны Гүйцэтгэх захирлын урамшууллын хуваарилалтын бүтэц - ТУЗ-ийн Нарийн бичгийн даргыг шинээр сонгох төлөвлөгөө, нэр дэвшигчдийн танилцуулга
3.	Д.Хулан (гишүүн)		100% (хурал тус бүр)	

- Засаглал, Цалин урамшуулан хороо

ТУЗ-ийн Засаглал, Цалин урамшууллын хороо нь компанийн засаглалын цогц зарчим, ёс зүйн дүрэм, компанийн засаглалын стратеги, гүйцэтгэл, тайлагналд хяналт тавих, Банкны урамшууллын системийн зорилгыг тодорхойлох, ТУЗ болон ТУЗ-өөс томилогддог эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан олгох хүрээнд ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн хуралд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

№	Гишүүдийн нэрс	Хурлын тоо	Гишүүдийн ирц	Хурлаар хэлэлцсэн асуудлууд
1.	А.Тамир (дарга, хараат бус гишүүн)	3	100% (хурал тус бүр)	Компанийн засаглал, БОНЗ-ын хүрээнд: - ХААН Банк ХК-ийн Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого - Банкны тухай хууль болон Төлөөлөн удирдах зөвлөлд холбогдох эрх зүйн зохицуулалтын асуудал - Засаглалын талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн сургалт - Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооны засаглалын үнэлгээ - 2024 оны Тогтвортой хөгжлийн тайлан Цалин, урамшууллын хүрээнд: - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын төсөв - Гүйцэтгэх захирлын 2024 оны үндсэн цалин - Гүйцэтгэх захирлын 2024 оны урамшуулал
2.	Т.Дарьбум (хараат бус гишүүн)		100% (хурал тус бүр)	
3.	Харада Ясүнари (гишүүн)		100% (хурал тус бүр)	

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

Банкны гүйцэтгэх удирдлагыг ТУЗ-өөс томилогдсон гүйцэтгэх захирал дангаараа хэрэгжүүлнэ. Гүйцэтгэх захирал нь Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хяналт тавина. Гүйцэтгэх захирал нь хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн гаргасан бүх шийдвэр, тогтоолын зохих хэрэгжилтийг хангана. Гүйцэтгэх захирал нь ажил үүргээ ТУЗ-тэй байгуулсан гэрээ болон холбогдох итгэмжлэлд заасан эрх хэмжээний дотор Банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах (Компанийн тухай хууль 83.1) бөгөөд Банкны гүйцэтгэх удирдлагыг Монголбанкны зөвшөөрснөөр (Банкны тухай хууль 31.3.2) ТУЗ томилж түүний үйл ажиллагаанд хяналт тавина. ТУЗ-ийн шийдвэргүйгээр ТУЗ-ийн аль нэг гишүүн, гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг хянан шалгах буюу гүйцэтгэх захиралд үүрэг, даалгавар өгөхийг хориглоно.

ТУЗ-ийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 18 тоот тогтоолоор хатагтай Р.Мөнхтуяа Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн ТУЗ-ийн 31 тоот тогтоолоор Гүйцэтгэх захирлын албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулахаар шийдвэрлэсэн болно.

Гүйцэтгэх захирлын өдөр тутмын болон шуурхай үйл ажиллагаа нь Удирдлагын хороо болон Өргөтгөсөн удирдлагын хороогоор дамжин хэрэгждэг. Удирдлагын хороо нь Гүйцэтгэх захирал, Бизнес хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч, Технологи, үйл ажиллагаа хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч, Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогчоос бүрддэг. Өргөтгөсөн удирдлагын хороо нь Удирдлагын хорооны харьяанд үйл ажиллагаа явуулах бөгөөд түүний бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр томилно. Эдгээр хороод нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагуудын хууль ёсны шийдвэр, Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-өөс гаргасан шийдвэр, тогтоолын хэрэгжилтийг хангуулах, зохион байгуулах зорилгоор банкны стратегийн зорилт, бизнес төлөвлөгөө, үндсэн үйл ажиллагаа болон бусад шаардлагатай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг болно. Хороод нь үндсэн чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсын нийгэм, эдийн засаг, улс төр, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан асуудал хэлэлцэж, мэдээлэл солилцдог.

Удирдлагын хорооны бүтэц:

- Р.Мөнхтуяа – Гүйцэтгэх захирал;
- Б.Эрдэнэдэлгэр – Бизнес хариуцсан Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч;
- Сачин Наир – Технологи, үйл ажиллагаа хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч;
- Г.Мөнхбаяр – Эрсдэл хариуцсан Гүйцэтгэх захирлын орлогч;

Өргөтгөсөн удирдлагын хорооны бүтэц:

- Д.Дугарбаатар – Ерөнхий аудитор;
- В.Янжинлхам – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;
- Ш.Өлзий-Аюуш – Санхүү хариуцсан дэд захирал;
- Д.Ариунбат – Иргэдийн банк хариуцсан дэд захирал;
- Т.Ууганбаяр – Байгууллагын банк хариуцсан дэд захирал;
- Ш.Ганбямба – Хүний нөөц хариуцсан дэд захирал;
- Ж.Товуудорж – Жижиг дунд бизнесийн банк хариуцсан дэд захирал;
- Ч.Чинболд – Бизнес хөгжил хариуцсан дэд захирал;
- Б.Ариунболд – Мэдээллийн технологи хариуцсан дэд захирал;
- О.Ариунтулга – Байгууллагын эрсдэл, комплаенс хариуцсан дэд захирал;
- Д.Өлзийжаргал – Санхүүгийн эрсдэл хариуцсан дэд захирал;
- Ю.Төрмөнх – Стратеги хариуцсан дэд захирал;
- С.Энх-Ирээдүй – Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал;
- Э.Нямцэнд – Цахим банкны захирал;
- Д.Даваажаргал – Аюулгүй байдлын захирал;
- Д.Жанибек – МТ-ийн тасралтгүй ажиллагааны захирал;
- Р.Ичинноров – Орон нутгийн Иргэдийн банкны захирал.

ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХААН Банкны Дотоод аудит нь банкны засаглал, эрсдэлийн удирдлага хяналтын тогтолцоонд бодитой байх зарчимд тулгуурласан хараат бус аудитын үйлчилгээ үзүүлэх замаар банкны үнэ цэнийг хамгаалах, нэмэгдүүлэх зорилгын дор үйл ажиллагаа явуулдаг. Дотоод аудитын үйл ажиллагаанд Дотоод аудиторуудын институтын (ИА) Дотоод аудитын олон улсын стандартууд болон Ёс зүйн дүрмийг баримталдаг. 2023 оны гуравдугаар улиралд олон улсын тэргүүлэгч байгууллагаар дотоод аудитын үйл ажиллагаандаа хөндлөнгийн чанарын үнэлгээ хийлгэж Дотоод аудитын олон улсын стандарт болон Ёс зүйн дүрэмд “Бүрэн нийцдэг” гэж үнэлэгдсэн.

Дотоод аудит нь зорилго болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Банкны тухай хууль, Компанийн зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны шууд удирдлагад харьяалагдаж, гүйцэтгэх

удирдлагаас хараат бусаар зохион байгуулагдсан. ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Ерөнхий аудиторын томилгоо, Дотоод аудитын дүрэм, стратеги болон жилийн төсөв төлөвлөгөөг батлах, аудитын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавих байдлаар Дотоод аудитын бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулдаг. Дотоод аудит нь тодорхойлсон зорилго, стратеги түүнийг хэрэгжүүлэх засаглалын зохистой зохион байгуулалтаараа банкны бизнесийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагааны зорилгыг дэмжих, хамгаалахад чиглэн ажиллаж байна.

ХААН Банкны Дотоод аудит нь банкны стратеги төлөвлөгөөтэй уялдуулсан дунд хугацааны стратегиа тодорхойлон ажилладаг. 2024 онд Дотоод аудитын бодлого, төлөвлөлтийн хүрээнд эрсдэл ба зорилго, стратегид суурилсан аудитын аргачлалыг хослуулан хэрэгжүүлэгч байх зорилтын хүрээнд байгууллагын стратеги, бизнесийн гол зорилтууд болон эрсдэлийн удирдлагад чиглэсэн аудитыг төлөвлөн банкны дунд хугацааны стратегийн гүйцэтгэл, тогтвортой бизнес стратеги хөгжлийн зорилго зорилтын хэрэгжилтийг баталгаажуулж, үйл ажиллагаагаа сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгч ажилласан.

ТУЗ-өөр батлагдсан “Дотоод аудитын дунд хугацааны стратеги төлөвлөгөө 2025-2027”-нд дотоод аудитын үйл ажиллагааны стандартын нийцлийг хадгалж, мэргэжлийн ур чадварыг сайжруулан, аудитын үйл ажиллагаанд технологид суурилсан арга аргачлалыг нэвтрүүлэх замаар дижитал хөгжлийн дараагийн түвшинд хүрсэн, үнэ цэнийг нэмэгдүүлэгч стратегийн түнш болох зорилтыг тодорхойлсон. Ийнхүү дотоод аудит нь банкны Засаглал болон эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг ирээдүйд чиглэсэн байдлаар үнэлэх, баталгаажуулах байдлаар стратегиа тодорхойлон ажиллаж байна.

Дотоод аудитын Дунд хугацааны стратеги төлөвлөгөө нь Банкны Тогтвортой хөгжлийн бодлогод тусгасан зорилтуудыг агуулдаг бөгөөд мэргэшсэн хүний нөөц бүрдүүлэх зорилтын хүрээнд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн БОНЗ-ын зөвлөх болон бусад зэрэг цол бүхий аудиторуудыг бэлтгэн ажиллаж байна.

Дотоод аудитын үндсэн чиг үүрэг:

- Салбарын аудитын газар нь Иргэдийн банкны салбар, тооцооны төвүүдийн засаглал, эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоо болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Төв банкны газар, албад, зээлийн хороодын үйл ажиллагаанд аудитыг хийж гүйцэтгэдэг.
- Төв банкны аудитын газар нь Төв банкны харьяа газар, хэлтэс, алба, хороодын үйл ажиллагаа болон төсөл, хөтөлбөрүүдийн засаглал, эрсдэлийн удирдлага болон хяналтын тогтолцоонд аудитыг хийж гүйцэтгэдэг.
- Мэдээлэл технологийн аудитын газар нь Банкны мэдээллийн технологи, мэдээллийн системийн үйл ажиллагаа, тэдгээрийн эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдлыг хамарсан аудитыг хийж гүйцэтгэдэг. Мөн ДА-ын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн систем хөгжүүлэлт, судалгаа шинжилгээ, мэдээлэл боловсруулалт зэргийг хариуцдаг.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк нь олон улсын шилдэг туршлага, зөвлөмж, стандарт болон Монгол Улсын зохицуулагч байгууллагуудын дүрэм, журам, шаардлагын дагуу эрсдэлийн удирдлагын тогтолцоогоо тогтмол сайжруулж, банкны бизнесийн үйл ажиллагаатай уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллаж байна.

ХААН Банкны эрсдэлийн удирдлага нь хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдэл (risk appetite statement)-ийн хүрээнд банкны стратеги, зорилтуудад нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах, тайлагнаж хянах замаар эрсдэлийг үр дүнтэй удирдахыг зорьж ажилладаг. Үүнд:

- Хүлээн зөвшөөрөх эрсдэл (risk appetite)-ийн хүрээнд эрсдэл, өгөөжийн харьцааг хамгийн оновчтой байлгах;
- Банкны эрсдэлийн удирдлагад оролцогчдын үүрэг, хариуцлагыг зохистой хуваарилах;
- Эрсдэлийн хүчирхэг соёлыг нийт ажилтнуудад төлөвшүүлэх;
- Банкны гол эрсдэлүүдийг олж илрүүлж, үр дүнтэй удирдах;

- Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах, хянах үйл явцыг олон улсын стандарт, зөвлөмж, шилдэг туршлагын дагуу сайжруулж, хэрэгжүүлэх

Бид дунд хугацааны стратеги зорилтын хүрээнд банканд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, стресс нөхцөл байдлыг даван гарах хангалттай хэмжээний өөрийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явц (ICAAP)” болон (ILAAP) -ыг Базелийн тогтолцооны стандартчилагдсан аргачлалд суурилан нэвтрүүлсэн. Түүнчлэн Монголбанкнаас 2024 оны Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд “Банкуудын зохистой засаглалыг сайжруулж, эрсдэлийн удирдлагыг оновчтой болгох хүрээнд банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй голлох эрсдэлүүдийг дотооддоо үнэлэх тогтолцоог бүрдүүлэх” зорилтыг тусгасан нь банкны дунд хугацааны стратегийн зорилттой хавсарсан зохицуулалтын шаардлагын үндэслэл болсон.

Банкны дунд хугацааны (2024-2026) тогтвортой бизнес стратеги болон 2024 оны бизнес төлөвлөгөөндөө ICAAP болон ILAAP-тай холбоотой тэргүүлэх зорилтуудыг тодорхойлж, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүний хүрээнд ХААН Банкны өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх үйл явцын бодлогыг шинээр боловсруулж, 2024 оны 4-р сард ТУЗ-өөр батлуулсан бөгөөд энэхүү бодлогод ICAAP-ын бүрэлдэхүүн хэсэг, баримтлах үндсэн зарчим болон үүрэг хариуцлагуудыг тодорхойлон тусгасан.

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

- Компанийн засаглалын кодекс

ХААН Банк нь өөрийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлсээр ирсэн. Энэ талаар ХААН Банк ХК-ийн Компанийн засаглалын кодекс-т тусгаж өгсөн. ТУЗ нь Банкны үйл ажиллагаанд оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичгийг батлах ба оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэн ажилладаг. Банк нь оролцогч талууд, хөрөнгө оруулагчдад өөрийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд, хэтийн төлөвийн мэдээлэл болон хөрөнгө оруулагч оролцогч талуудад хамаарах санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг хангаж, оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ. ХААН Банк нь хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчил, шударга бус байдлыг мэдээлэх боломжийг хангах “Шүтэл үлээх бодлого” болон мэдээллийг үнэн зөв, ил тод, цаг хугацаанд нь хүргэх “Мэдээллийг ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого” зэрэг дээр дурдсан засаглалын 16 бодлого, журмуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

- Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр

“ХААН Банк ХК-ийн Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр” нь хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд чиглэсэн олон төрлийн зорилго, арга хэмжээг агуулдаг. Тус хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй гол зорилгууд нь, компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах, хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах, баталгаажуулах, ТУЗ болон Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтны хариуцлагын тогтолцоог олон улсын жишигт хүргэх, тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах, эрсдэлийн удирдлагыг сайжруулах, дотоод аудит, хяналтын тогтолцоог сайжруулах, Банкны цалин, урамшууллын бодлогыг оновчтой тодорхойлох, Банкны ёс зүйн дүрмийг чанд мөрдөх юм. Бид тус хөтөлбөрөөр Банкны дотоод бодлогын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг СЗХ-ны "Компанийн засаглалын кодекс"-ийн зарчимд нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэхээр зорьж байна.

- Ёс зүйн дүрэм

ХААН Банкны Ёс зүйн дүрмийг 2023 онд шинэчлэн баталсан бөгөөд тус Дүрмийн 1.2-т заасны дагуу харилцагч, ажлын түнш, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, банкны ажилтнуудын ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийн хоорондын харилцааны үндсийг тодорхойлох зорилтыг хэрэгжүүлдэг болно. Ёс зүйн дүрэм нь ХААН Банкны үнэт зүйлсийн тунхаг бичигт тусгасан эрхэмлэх үнэт зүйлсийг бэхжүүлэх, харилцагч, ажил хэргийн түнш, хувьцаа эзэмшигчид, ТУЗ-ийн гишүүд, банкны ажилтнуудын өмнө хүлээсэн, албан үүрэг, хариуцлагаа биелүүлэх, тэдний ашиг сонирхлыг хамгаалах, тэдгээрийг хоорондын харилцааны үндсийг тодорхойлох зорилтыг хэрэгжүүлнэ. ХААН Банкны Ёс зүйн дүрмийн 6.3-т заасны дагуу Банк нь оролцогч талуудын үр дүнтэй

харилцаа холбоо үүсгэх, хууль бус хөдөлмөр эрхлэлтийн эсрэг сайн туршлага хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын нэгдэн орсон НҮБ, Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас баталсан Конвенц, олон улсын бусад хэм хэмжээг мөрдлөг болгон ажилладаг.

- Хөрөнгө оруулагчидтай харилцах бодлого

МХБ-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани болохын хувьд Банк нь өөрийн удирдлага, үйл ажиллагаа, санхүүгийн байдал, цаашдын төлөв, алсын харааны талаарх мэдээллийг тодорхой, шударга, тэнцвэртэй хүргэх үүргээ хэрэгжүүлэхээр зорьж байгаа билээ. Энэ хүрээнд “ХААН Банк ХК-ийн Хөрөнгө Оруулагчидтай Харилцах Бодлого”-ыг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус бодлогын зорилго нь хөрөнгө оруулагчид болон боломжит хөрөнгө оруулагчдыг хөрөнгө оруулалтын тухай шийдвэр гаргахад мэдээллээр хангах, бусад оролцогчдод банк, түүний зорилгын талаар тэнцвэртэй ойлголтыг хүргэхэд банкныг шударга, үнэн зөвөөр төлөөлөх явдал юм. Хөрөнгө оруулагчидтай харилцахдаа хувьцаа эзэмшигчдийн хурлын үеэр тухайн хурлын хэлэлцэх асуудлын хүрээнд холбогдох тайлан, мэдээ мэдээллийг хэлэлцэж, санал авах, асуулга зохион байгуулж, цахимаар болон биечлэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол хүлээж авч, ХААН Банкны болон МХБ-ийн албан ёсны цахим хуудсууд, эсвэл биечлэн мэдээлэл хүргэж, мөн Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагаас баталсан дүрэм, журам, Банкны Дүрэм, болон бусад холбогдох дүрэм, журамд нийцүүлэн шаардлагатай бусад арга хэрэгслээр мэдээлэл солилцож ажилладаг.

- Мэдээллийн ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого

ХААН Банк олон нийт, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч болон зохицуулагч байгууллагуудад Банкны мэдээллийг үнэн зөв, бүрэн бүтэн, тэнцвэртэй байдлаар цаг хугацаанд нь толилуулах зорилгын хүрээнд “ХААН Банк ХК-ийн Мэдээллийг ил тод байдал, мэдээллийг толилуулах бодлого”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Банк нь мэдээлэл толилуулахдаа үнэн зөв, хүртээмжтэй, цаг тухайд нь, бүрэн бүтэн, бодитой, эерэг болон сөрөг талуудыг агуулсан тэнцвэртэй байдлыг хангаж, холбогдох хууль, тогтоомж, Банкны Дүрэм, дээр дурдсан бодлого болон бусад дотоод баримт бичгүүдийн дагуу ил тод байдал болон бизнесийн ашиг сонирхлын хоорондын зохих тэнцвэрийг хадгалахыг эрмэлзэнэ. Мэдээллийг толилуулахдаа холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу Банкны албан ёсны цахим хуудас, МХБ-ийн албан ёсны цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эсвэл мэдээллийг саадгүй хүргэх боломжийг хангасан бусад хэлбэрээр хүргэж ажиллана.

- Шүтэл үлээх бодлого

ХААН Банк нь компанийн зохистой засаглалыг хэрэгжүүлж, байгууллагын хэмжээнд бизнесийн ёс зүй, ил тод байдал, хариуцлага болон шударга байдлыг мөрдөж ажилладаг ба үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудаас баталсан дүрэм, журмын дагуу явуулдаг. Бид аливаа хууль бус үйлдэл, ёс зүйн зөрчил ба шударга бус байдлыг эмээх зүйлгүйгээр банканд мэдээлэх боломжийг ажилтнуудад, харилцагчдад болон бусад хамтран ажиллаж буй хувь хүн, байгууллагуудад олгож шүтэл үлээх тогтоолцоог дэмжиж “ХААН Банк ХК-ийн Шүтэл үлээх бодлого”-ыг хэрэгжүүлж ажилладаг. 2024 онд шүтэл үлээх явцыг цахимжуулж, ХААН Банкны албан ёсны цахим хуудаст “Шүтэл үлээх” цэсийг оруулж өгсөн. Энэ нь харилцагч, ажилтнууд болон бусад оролцогч талууд аливаа зөрчил, хууль бус үйлдлийг илрүүлсэн тохиолдолд мэдээллийг аюулгүй, нууцлалтай, шуурхай дамжуулах боломжийг бүрдүүлсэн чухал алхам болж, засаглалын ил тод байдлыг нэмэгдүүлж буй юм.

6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
2024 онд Монгол улсын эдийн засаг уул уурхай болон дотоод эрэлт хэрэгцээний идэвхжлээс шалтгаалж өсөлт өндөртэй байсан ч БНХАУ-ын эдийн засгийн удаашрал, ОХУ болон Украйны дайн зэрэг геополитикийн эрсдэл өндөртэй, гадаад орчны тодорхой бус байдалтай нүүр тулсан жил байлаа. Гэвч банк нь зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хүү, гадаад валютын ханш болон үнийн өөрчлөлт зэрэг зах зээлийн хувьсагчдын өөрчлөлтөөс шалтгаалан банкны эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ, ирээдүйн мөнгөн урсгалын хэлбэлзлээс хүлээж болзошгүй алдагдлыг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинд удирдаж ажиллалаа.	

Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсэж болзошгүй алдагдлыг тэдгээрийн эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор Монголбанкнаас тогтоосон тухайн нэг болон нийт гадаад валютын нээлттэй позицын хязгаарлалтуудыг хангахын зэрэгцээ “Хамгийн их эрсдэлийн арга”-аар эрсдэлээ өдөр тутам хэмжин, удирдаж ажилладаг. Банкны гадаад валютын эрсдэлийн үнэлгээний “VaR” програм хангамж нь гадаад валютын нээлттэй позицоос хүлээх ханшийн эрсдэлийг 99 хувийн итгэх магадлалын түвшинд түүхэн эх үүсвэр, вариаци-ковариаци болон симуляцын аргачлалуудыг ашиглан тооцож мөн удирдлагын мэдээллийн систем болон эрсдэлийн үнэлгээний найдвартай, үнэн зөв бөгөөд бүрэн бүтэн байдлыг хангахад чиглэсэн стандарт тоон ба чанарын шаардлагуудад нийцүүлэн тогтмол хөгжүүлэлтүүдийг хийдэг.

Үүний зэрэгцээ зах зээл дэх хүүний түвшний өөрчлөлт нь богино хугацаанд банкны цэвэр хүүгийн орлогод шууд нөлөөлдөг бол урт хугацаанд өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнд нөлөөлдөг. Банк нь банкны хяналт, шалгалтын Базелийн хорооноос боловсруулсан аргачлал, түүнд тодорхойлсон хүүний түвшний стандарт болон шокийн сценари хувилбаруудыг ашиглан хүүний түвшний эрсдэлээ хэмжиж, лимит тогтоох замаар сөрөг нөлөөллийг хязгаарладаг. Үүнд:

- Арилжааны бүртгэлийн хүүний түвшний эрсдэлийг хөрвөх чадвараар тохируулсан хамгийн их эрсдэлийн аргачлалд суурилан;
- Банкны бүртгэлийн хүүний түвшний эрсдэлийг орлого болон эдийн засгийн өртгийн хандлагын аргачлалуудаар хэмжиж, удирддаг.

Түүнчлэн Банк нь өөрийн үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан үүсэж болох эрсдэлийг урьдчилан тооцож түүнийг тэсвэрлэх хангалттай хэмжээний өөрийн хөрөнгө ба төлбөрийн чадварыг хадгалах эсвэл шаардлагатай нэмэлт нөөцийг хэрхэн бүрдүүлэх болон эрсдэлийн түвшинг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн стресс тестийн шинжилгээг улирал тутам хийж гүйцэтгэдэг. Банк нь олон улсад өргөн ашиглагддаг шилдэг туршлага, стандартыг жишиг болгон зах зээлийн эрсдэлийг хэмжих загвар ба аргачлалыг хөгжүүлэх, үр ашигтай дотоод эрсдэлийн лимит тогтоох үйл явцыг бий болгох болон эрсдэл бууруулах арга хэрэгслүүдийг ашиглах замаар эрсдэлийн удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулж ажиллахыг зорьдог.

7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл
----	---

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, ХААН Банк ХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу ХААН Банк ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах замаар тус Банкныг удирдах ба хувьцаа эзэмшигчид хуралд өөрсдийн эзэмшиж буй хувьцааны тоогоор саналын эрхтэй оролцоно.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх

Банкны Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл болон ХААН Банк ХК-ийн Дүрмийн 7.2-т тус тус заасан асуудлуудыг хэлэлцэх, шийдвэрлэх бүрэн эрхтэй байна.

ХААН Банк ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулдаг бөгөөд 2024 оны ээлжит хурлыг 4 дүгээр сарын 23-ны өдөр танхим болон цахим хосолсон хэлбэрээр амжилттай зохион байгуулсан. Хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид 87.76 хувийн ирцтэй оролцож, дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. “ХААН Банк” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт;
2. ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв;

3. “ХААН Банк” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын төсөл.

Хувьцаа эзэмшигчид дээрх асуудлуудтай холбогдох тайлан илтгэлүүдийг сонсож, мэдээлэл, тайлбартай танилцан, асуулт хариулт болон санал хүсэлтээ хэлэлцсэний эцэст саналын хуудсаар саналаа өгч батлав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материал болон шийдвэрүүдийг ХААН Банкны цахим хуудасны Хөрөнгө оруулалт цэсний Хувьцаа эзэмшигчид дэд хэсгээс харна уу

ХУВЬЦАА ЭЗЭМШИЛИЙН БҮТЭЦ

Банк нь нийт 3,000,000,000 ширхэг зарласан хувьцаатай ба үүнээс гаргасан хувьцаа 1,912,198,000 ширхэг байна. Компанийн гаргасан хувьцааг дараах хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Үүнд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь	Хувьцааны тоо ширхэг
1	Эйч Эс Холдингс ХК	40.99%	783,882,300
2	Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед ХХК	8.78%	167,856,050
3	Таван Богд Холдингс ХХК	22.78%	435,653,100
4	Д.Хулан (хувь хүн)	13.22%	252,738,000
5	Олон нийт	14.23%	272,068,550
Нийт:		100.00%	1,912,198,000

Хувьцаа эзэмшигчдийн талаар:

Эйч Эс Холдингс ХК	“Эйч Эс Холдингс” ХК нь 1958 онд анх үүсэн байгуулагдсан бөгөөд хувьцаагаа олон нийтэд арилжаалдаг (Токиогийн хөрөнгийн биржийн бүртгэлийн дугаар: 8699) нээлттэй хувьцаат компани юм. Тус компани нь гол төлөв үнэт цаасны арилжаа, зуучлал, хоёрдогч бүтээгдэхүүнээс гадна компаниудад үнэт цаас гаргаж, тэдгээрийг бусдад санал болгох, арилжих үйлчилгээ, мөн банк, үл хөдлөх хөрөнгө, шинээр үйл ажиллагаагаа эхэлж буй компаниудад хөрөнгө оруулах зэрэг санхүүгийн олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг.
Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед ХХК	“Эйч Эс Интернэйшнл (Ази) Лимитед” ХХК нь “Эйч Эс Холдингс” ХК-ийн 100 хувийн эзэмшлийн Хонконг дахь охин компани юм. Тус компани нь Хятад болон Ази тивийн эдийн засгийн өсөлтөд тулгуурлан “Эйч Эс Холдингс” ХК-ийн Ази дахь стратегийг хэрэгжүүлж, бүс нутгийн улс орнуудын зах зээлийн судалгаа хийхээс гадна Хонконгийн зах зээл дээр бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг.
Таван Богд Холдингс ХХК	“Таван Богд Холдингс” ХХК нь “Таван Богд” группийн толгой компани бөгөөд 1997 онд группийн бодлого стратеги, менежментийг нэгдсэн байдлаар тодорхойлох, шинэ бизнесийг нээн хөгжүүлэх, хөрөнгө оруулалт болон салбар компаниуддаа менежментийн дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулагдсан. “Таван Богд” групп нь худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл, аялал жуулчлал болон зочид буудал, уул уурхайн тоног төхөөрөмжийн бэлтгэн нийлүүлэлт, банк санхүү зэрэг салбарт үйл ажиллагаа явуулдаг. “Таван Богд” группийн эзэмшилд “Товь” ХК, “Улаанбаатар гурил” ХХК, “Эйрлинк Монголиа” ХХК, “Кемпински Хаан палас” зочид буудал зэрэг нэр хүндтэй ААН-үүд багтдаг. Мөн “Toyota”, “Volkswagen”, “Bridgestone” болон “Херох” брэндийн албан ёсны дистрибьютер бөгөөд “KFC”, “Pizza Hut”, “Subway” брэндийн сүлжээ ресторануудын Монгол Улс дахь албан ёсны франчайз эрхийг эзэмшдэг.

Д.Хулан (хувь хүн)	Монгол Улсын иргэн Д.Хулан нь “Таван Богд” группийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч бөгөөд өдгөө “Таван Богд” группийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Банкны ТУЗ-ийн ердийн гишүүн, ТУЗ-ийн дэд дарга тэрээр 2010 оноос бие даасан хувьцаа эзэмшигч болсон.
Олон нийт	ХААН Банк нь Банкны тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр анхдагч зах зээлийн арилжааны нээлт хийж, нийт хувьцааныхаа 10 хувь буюу 191,219,800 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгон амжилттай арилжаалсан билээ. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд хамгийн өндөр дүнтэй, хамгийн олон захиалга авсан, хамгийн олон хөрөнгө оруулагчидтай, хамгийн хүртээмжтэй анхдагч зах зээлийн арилжаа болсон. Банкны ажилтанд хувьцаа худалдах хөтөлбөрийг мөн хэрэгжүүлсэн бөгөөд 4136 ажилтны хувьцааг бүртгэж, хадгалсан. Банкны хувьцааг эзэмшигчид хүссэн үедээ хувьцааны арилжаанд оролцох боломжтой болсон тул хувьцаа эзэмшигчдийн бүтцэд “Олон нийт” хэсэгт тооцогдох болсон. 2024 оны байдлаар ХААН Банкны нийт хувьцааны 272,068,550 ширхэг хувьцаа буюу 14.23 хувийг олон нийт эзэмшиж байна.

8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
----	--

ХААН Банк нь 2023 оны 04 дүгээр сарын 13-ний өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хооронд олон нийтэд 959 төгрөгийн нэгж үнэ бүхий 191,219,800 ширхэг энгийн хувьцааг санал болгох замаар нийт 183.4 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Тус Банк нь энгийн хувьцааг нийтэд санал болгон арилжсанаар өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээс гадна татан төвлөрүүлэх хөрөнгийн 16 хувийг банкны бүтээгдэхүүн үйлчилгээний цахим шилжилтийг хурдасгах мэдээллийн технологийн хөрөнгө оруулалтад, 19 хувийг цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, шинэчлэлтэд, 34 хувийг ногоон төсөл хөтөлбөрүүдэд болон 31 хувийг урт хугацаатай хөрөнгө оруулалтын зээл, орон сууцны зээл санхүүжүүлэхэд зарцуулахаар төлөвлөсөн.

Мөн дунд хугацаанд харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, зайнаас хүргэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвараа сайжруулахад чиглэсэн цахим шилжилтийн зорилтуудаа хэрэгжүүлэх, зах зээлд эзлэх байр сууриа хадгалах, тэлэх зорилтуудыг дэвшүүлсэн.

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт 2024 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар дараах байдалтай байна. Үүнд:

№	Зарцуулалт	Эзлэх хувь	ТТХ дүн /төгрөг/	Зарцуулалт	Эх үүсвэрийн үлдэгдэл
1	Мэдээллийн технологийн хөрөнгө оруулалт	16%	29.3 тэрбум	29.3 тэрбум	0
2	Цахим бүтээгдэхүүний хөгжүүлэлт, сайжруулалт	19%	34.8 тэрбум	34.8 тэрбум	
3	Ногоон төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилт	34%	62.4 тэрбум	62.4 тэрбум	
4	Урт хугацаат зээл /Орон сууц, хөрөнгө оруулалтын санхүүжилт/	31%	56.9 тэрбум	56.9 тэрбум	
	Нийт	100%	183.4 тэрбум	183.4 тэрбум	

Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийг зарцуулж дууссан болно.

9.	Ногдол ашгийн мэдээлэл
	“ХААН Банк ХК-ийн Ногдол ашгийн бодлого”-ыг Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10-р сарын 25-ны өдрийн 26 тоот тогтоолоор шинэчлэн баталсан. Ногдол ашгийн бодлогын зорилго нь Банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс баримтлах ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журмыг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон зохицуулагч байгууллагуудаас гаргасан холбогдох дүрэм, журамд нийцүүлэн тодорхойлоход оршино. Тус Бодлогод заасны дагуу Банк нь жил бүр татварын дараах цэвэр ашгийн 40 хувиас дээш хувиар ногдол ашиг хуваарилахыг эрмэлзэж ажилладаг ба зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлдэг компанийн хувьд Монголбанкнаас зөвшөөрөл олгосноор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаа тараах эрхтэй болдог. ХААН Банкны ТУЗ-ийн 2024 оны 2-р сарын 15-ны өдрийн 04 тоот тогтоолын дагуу 2024 оны татварын дараах цэвэр ашиг болох нийт 558 тэрбум төгрөгөөс банкны өөрийн эрсдэл даах чадвар, өөрийн хөрөнгийн зохистой харьцааг зохих хэмжээнд барих нөхцөлийг хангасны үндсэн дээр нэгж хувьцаанд 141.73 төгрөг буюу 1,912,198,000 ширхэг энгийн хувьцаанд нийт 271 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу зохицуулагч байгууллагын зөвшөөрлийг хүлээн авсны дараа 2024 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваарилж дууссан болно.
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	ХААН Банк нь 2007 онд ХААН Банк Санг дэргэдээ байгуулан нийгмийн хариуцлагын төсөл, хөтөлбөрүүдээ системтэйгээр хэрэгжүүлж ирсэн бөгөөд энэ хугацаанд нийт 523 төсөл, хөтөлбөрт, 16.2 тэрбум төгрөгийн санхүүжилт үзүүлсэн. ХААН Банк Сан нь төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх дараах тэргүүлэх чиглэлтэй. Үүнд: 1. Олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах; 2. Хүүхэд залуусын боловсролыг дэмжих; 3. Байгаль орчноо хамгаалах; 4. Орон нутгийн хөгжлийг дэмжих; 5. Нийгмийн эмзэг бүлгийг дэмжих; 6. Соёл, урлагийг дэмжих; 7. Тогтвортой хөгжлийн 17 зорилгод хувь нэмэр оруулах. Тайлант хугацаанд ХААН Банк Сан нь 13 төсөлд 3,5 тэрбум төгрөгийн санхүүжилт үзүүлж, Монгол улсын өнцөг булан бүрт амьдарч буй иргэдийн амьдралд, бодитой хувь нэмэр оруулан ажилласан. • Эрүүл мэндийн чиглэлд: Хавдар судлалын үндэсний төв, Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран хэрэгжүүлдэг “Хавдрын эсрэг үндэсний аян”-ыг 14 дэх жилдээ хэрэгжүүлж аяны хүрээнд Баян-Өлгий, Баянхонгор аймгуудад ажиллаж 3,021 иргэдийг хавдар өвчний нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоонд хамруулав. Мөн 2017 оноос хойш Улсын Гуравдугаар Төв эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв болон Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран хэрэгжүүлж буй “Цусны даралт ихсэлтийн эсрэг аян”-ыг Хэнтий, Говьсүмбэр, Сүхбаатар, Дорнод аймгуудын 16,584 иргэдийг үзлэгт хамруулан, эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн билээ. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн санаачилга “Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд аян”-д санхүүжилт үзүүлж, олон нийтэд чиглэсэн 3 удаагийн контент бүтээв. • Боловсролын чиглэлд: “ХААН Банкны нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 18 дах жилдээ зарлан, 100 оюутанд сургалтын төлбөрийн тэтгэлэг олгов. Сурагчийн ширээнээс оюутны амьдралд хөл тавьж буй шинэхэн оюутнуудад зориулсан "Rise шинэ оюутны хөгжлийн хөтөлбөр"-ийг ХААН Банк нь 7 дах жилдээ амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд 2024 онд анх удаа орон нутгийн залуучуудад зориулан Дархан хотод зохион байгуулагдан, тухайн хотын их, дээд сургуулийн 500 оюутан хөтөлбөрт хамрагдсан. НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтын ажиллагааны хүрээнд бүх нутгийг хамарсан зудыг даван туулахад малчид болон малчдын хүүхдүүдэд туслах хандивт нэгдсэн. Мөн жил бүрийн 11-р сарын 20-ны өдөр тохиодог Дэлхийн хүүхдийн өдөр НҮБ-ын Хүүхдийн Сангийн “Go blue” аянд нэгдэж тус өдөр цэнхэр гэрлээр өөрийн оффисыг гэрэлтүүлсэн билээ. Мөн тус аяны хүрээнд зохион байгуулагддаг хандивын гала арга хэмжээнд ивээн тэтгэгчээр оролцож, “Таблеттай багш” санаачилтад санхүүжилт үзүүлэв. Байгаль эх дэлхийгээ хайрлах ухааны тухай өгүүлэх “Ангараг гаргийн зүгт” хүүхдийн номыг 1000 хувь хэвлэх зардлыг санхүүжүүлж, ЕБС-уудын номын санд хандивлав. Монгол дах “Азийн сан” олон улсын байгууллагатай хамтран “Нярайн номтой

багц” төслийг хэрэгжүүлж нийслэлийн Хүрээ амаржих газар дөнгөж мэндэлсэн нярайд 400 ширхэг багцыг бэлэглэлээ.

- Байгаль орчны чиглэлд: Монгол орон даяар байрлах салбар нэгжүүдээр дамжуулан тухайн аймагт орон нутагтаа мод тарьсны дээр “ХААН Банкны ой” ойжуулах хөтөлбөрийн хүрээнд Сэлбэ голын эх Их баяны аманд байрлах 40 га газрыг ойжуулах ажлын сүүлийн 16 га талбайн тарилтыг гүйцэтгэж дуусав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монголбанк, Монголын Банкны Холбооноос байгуулсан Тэрбум мод сангаар дамжуулан 435,709 модыг тарьсан.
- Орон нутгийг дэмжих чиглэлд: ХААН Банк нь 2021 онд Монгол улс даяар нийт 33 байршилд 3х3 сагсан бөмбөгийн орчин үеийн жишиг талбайг байгуулсан бөгөөд 2024 онд уг талбайнууд дээр 3 дах жилдээ ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд нөхөрсөг тэмцээн зохион байгуулж, 2,300 гаруй хүүхэд залуус тэмцээн оролцов. Мөн энэ оны хувьд бас нэг онцлог нь мэргэжлийн тамирчид инфлүнсэрүүдээс бүрдсэн баг Хөвсгөл, Сүхбаатар, Дархан-Уул аймгуудад 3х3 сагсан бөмбөгийн өдөрлөг зохион байгуулсан. Нярай хүүхэдтэй салбарт ирж үйлчлүүлж буй харилцагч нарт үйлчлүүлэх таатай орчинг бүрдүүлэх зорилгоор орон нутгийн салбаруудад хүүхэд хуурайлах булан хүүхэд хөхүүлэх булангуудыг байгууллаа.
- Нийгмийн эмзэг бүлэг чиглэлд: 2024 онд 6 дах жилдээ хэрэгжиж буй Парабочи спортыг дэмжих төслийн хүрээнд Парабочигийн улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах болон олон улсын тэмцээнд оролцоход санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан. Тус хамтын ажиллагааны үр дүнд Монгол улс анх удаа парабочи спортыг төрлөөр ОУ-н тэмцээнээс медаль хүртэл дэлхийн ранкыг ахиуллаа.
- Соёл урлаг чиглэлд: ХААН Банк нь “Монголын урлагийн зөвлөл”-тэй хамтран 2 дахь удаагаа “Би чадна - Бид авьяастай” кино урлагаар дамжуулан оюуны ялгаатай болон хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын тухай богино хэмжээний кино бүтээх төслийг хамтран хэрэгжүүлж, 2024 онд харааны бэрхшээлтэй хүүхдүүд болон мэргэжлийн кино бүтээгчдийн оролцоотойгоор “Солонгод хүрэх зам” богино хэмжээний киног бүтээв.

Хүрээлэн орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд банкны тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлсийг банкны Тогтвортой хөгжил, БОНЗ-ын тайлангийн “Оролцогч талуудын оролцоо, давхар материаллаг байдлын үнэлгээ” хэсгээс дэлгэрэнгүй мэдээллийг харна уу.

ХААН Банк 2024-2026 оны дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд дараах зорилго, зорилтыг тодорхойлсон. Үүнд:

- 1) ХААН Банкны ТХ-ийн бодлогыг ТХЗ ба ҮТХН-тэй нийцүүлэн өргөжүүлж, БОНЗ-ын тэргүүлэх чиглэл ба үзүүлэлтүүдэд хэмжигдэхүйц зорилтыг тогтоох.
- 2) БОНЗ болон тогтвортой байдлын тайланг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах.
- 3) Тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалт, компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд тогтвортой хөгжлийн 17 зорилгод хувь нэмрээ оруулах.

Банк нь уламжлалт эрсдэлүүдийг үр дүнтэй удирдахаас гадна гадаад, дотоод орчны өөрчлөлт, цахим шилжилт, технологийн хөгжлөөс үүдэн шинээр үүсч буй эрсдэлүүдэд тогтмол анхаарал хандуулан ажиллаж байна. Үүний хүрээнд холбогдох үйл явц, бодлого, журам болон арга хэрэгслүүдийг шинээр боловсруулж, сайжруулахын зэрэгцээ эрсдэлийг урьдчилан илрүүлэх, үнэлэх, хянах аргачлалуудыг бүрэн хэрэгжүүлэхээр зорьж байна.

Хүлээн зөвшөөрөх эрсдэл нь банкны эрсдэлийн удирдлагын тогтолцооны чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд жил бүрийн стратеги, бизнесийн зорилтод нийцүүлэн Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийг шинэчилж, баталдаг. Уг мэдэгдлийн хэрэгжилт болон гүйцэтгэлийг сар бүр Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хороо болон ТУЗ-д тайлагнаж байна. 2025 оны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн мэдэгдлийн хүрээнд банкны зорилго зорилт болон зохицуулагч байгууллага, зээлдүүлэгч байгууллагын шаардлагад сөргөөр нөлөөлөх байгаль орчин, нийгмийн эрсдэл (уур амьсгалын эрсдэл)-ийг бага түвшинд байлгах зорилгоор уур амьсгалын нөлөөллийн эрсдэлийг бууруулах үзүүлэлтүүдийг тодорхойлон баталсан. Мөн банк нь үйл ажиллагааны тэсвэртэй байдлыг хангах хүрээнд биет болон мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах холбогдох үзүүлэлтүүдийг тодорхойлон баталсан.

Түүнчлэн Банк нь гол эрсдэлүүдийг удирдах, хянах арга хэрэгсэл болгон эрсдэлийн самбарыг ашигладаг. Энэхүү самбар нь банкны зорилтод нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, тогтмол хянах замаар гол эрсдэлүүдийг үр дүнтэй удирдах зорилготой бөгөөд үүний хүрээнд “Уур амьсгалын нөлөөллийн эрсдэл”, “Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлүүд”-ийг тодорхойлж, тусгасан ба тус эрсдэлүүдийн түвшинг сар тутам үнэлдэг. Байгууллагын нэгдсэн эрсдэлийн удирдлагын хороо нь сар бүр арга хэмжээний гүйцэтгэл болон эрсдэлийн түвшинд хяналт тавьж ажилладаг. Түүнчлэн чиглэл хариуцсан эрсдэлийн дэд хороод болох Үйл ажиллагааны эрсдэлийн дэд хороо, Аюулгүй байдлын эрсдэлийн дэд хороод нь хариуцсан эрсдэлүүдийг нэгдсэн байдлаар хянаж удирдаж, холбогдох шийдвэрүүдийг гаргадаг.

Банкны нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд дараах эрсдэлүүд байна. Үүнд:

1. Эрсдэлтэй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, хандив олгох - Нийгэмд сөрөг үр дагавар авчрах төслийг санхүүжүүлж, хандив олгосноор Банкны нэр хүндэд муугаар нөлөөлөх эрсдэл бий;
2. Хувийн болон төрийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах явцад үүсэх нэр хүндийн эрсдэл - Хувийн болон төрийн байгууллага зэрэг оролцогч талуудтай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх явцад тухайн оролцогч талуудад үүссэн нэр хүнд, үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдэл, асуудал бий болсноор хамтран хэрэгжүүлж буй төсөл амжилтгүй болох, олон нийтэд банкны нэр хүнд унах эрсдэл бий;
3. Гэрээний хүрээнд тодорхойгүй нөхцөл үүсэх эрсдэл - Ажил гүйцэтгэх гэрээ байгуулахдаа гэрээнд нарийвчлан тусгаагүй асуудал гарч ирэх мөн нууцлалтай мэдээлэл алдагдах, нууцлалын гэрээ зөрчих эрсдэл үүсч болно.

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Р.Мөнхтуяа

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

Он, сар, өдөр: 2025 он 04 сар 30 өдөр

